

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС 2023

Мониторингийн тайлан



“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индекс 2023: Мониторингийн тайлан”-г IRIM судалгааны хүрээлэн өөрсдийн санаачилгаар 12 дах жилдээ хийж гүйцэтгэв.

Мониторингийн тайлангийн үр дүнг ашиглах бол эх сурвалжийг дурдана уу.

IRIM. Цахим ил тод байдлын индекс, УБ., 2023

Мониторингийн баг

Хүрэлчулуун Баярмаа

Ахлах судлаач

Баянбат Шинэцэцэг

Зохицуулагч, Судлаач

Болдын Болор

Дата менежер

Жоэл Вулф




Судлаач

Эх бэлтгэл, дизайн

Болдын Болор

Дата менежер

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ СУДАЛГААНЫ ӨМНӨХ ТАЙЛАНГУУД



* Зураг бүр дээр дарж тайлан тус бүртэй танилцах боломжтой. Нийт тайланг: <http://irim.mn/web-monitoring>

АГУУЛГА

Удиртгал	5
1. Арга зүй	7
1.1. Индексийн зорилго, зорилт	7
1.2. Индексийн хүрээ	8
1.3. Индексийн бүтэц ба хэмжих аргачлал	11
2. Үр дүн	13
2.1. Нэгдсэн үр дүн	13
2.1.1. Цахим ил тод байдлын өөрчлөлт	13
2.2. Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн	14
2.2.1. Мэдээллийн ил тод байдлын олон улсын харьцуулалт	15
2.2.2. Мэдээллийг ил тод болгох бодлогын орчны нөхцөл байдал	17
2.2.3. Төрийн байгууллагын мэдээллийг ил тод болгох чадамж, бэлэн байдал	19
2.2.4. Цахим мэдээллийн нээлттэй байдал	21
2.3. Байгууллагуудын үр дүн	24
3. Дүгнэлт, зөвлөмж	25
Хавсралт 1. Арга зүй: Хэмжих индикаторууд, харгалзах оноо	27
Хавсралт 2. Байгууллагын төрөл тус бүрийн эрэмбэ	28
Хавсралт 3. Нийт үнэлсэн төрийн байгууллагуудын эрэмбэ	32

Удиртгал

Хүн төрөлхтний хөгжлийн түүхийг эргэн харахад XIX зууны үеэс автоматжуулсан үйлдвэр амьдралд нэвтэрч, аж үйлдвэрт гарсан томоохон өөрчлөлт ахицын эхлэл байсан. Харин өнөө үед Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал эхэлж хиймэл оюун ухаанд суурилсан цахим хувьсгал, дижитал шилжилтийн эрин үе нь хүн төрөлхтний амьдралын салшгүй нэг хэсэг болжээ. Мэдээлэл, харилцаа, холбооны технологи (МХХТ)-ийн хэрэглээ дэлхий дахинд хурдацтай нэвтэрч засгийн газар, хувийн хэвшил, олон нийтийн болон бизнесийн уламжлалт хэв маягийг дахин хэлбэржүүлж дараагийн түвшинд хурдацтай шилжих үйл явц өрнөж байна. Энэхүү МХХТ-ын дэвшил нь иргэд, олон нийтэд газар зүйн байршлаас үл хамааран ил тод, нээлттэй мэдээллийг цаг мөч алдалгүй түргэн шуурхай хүрэхэд хамгийн чухал хэрэгсэл юм.

Дэлхий дахинд МХХТ-ийн хөгжил дэвшилд дасан зохицох, хөл нийлүүлэн хөгжих сорилт тулгарч байгаа ба тэр дундаа нийгмийн салбарт уламжлалт хэв маягаас дараагийн түвшинд шилжих үйл явцад сорилтууд ихээхэн тулгарч байна. Ялангуяа төрийн байгууллагад инновацын шинэчлэлүүд дутагдаж байгаа төдийгүй шилжилт, шинэчлэл, хөгжил удаашралтай явагдаж байна. МХХТ-ийн хөгжлийн хамгийн чухал хэсэг нь газар зүйн байршлаас үл хамааран төрийн байгууллагын ил тод байдлыг хангах, мэдээлэл авах эрхийг сурталчлахад хувь нэмэр оруулах явдал юм. Нөгөөтээгүүр иргэд болон талуудын төрийн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг МХХТ ашиглан нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүсэж буй юм. Тиймээс цахимаар хүргэж буй төрийн мэдээллийн ил тод байдал хэр байгааг хэмжих, үр дүнг илүү нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байсаар байна.

НҮБХХ-ийн хүрээнд анх цахим засаглал нэр томьёонд тулгуурлан МХХТ-ийн хөгжил

дэвшлийг төрийн удирдлагад нэвтрүүлэх ажлыг эрчимтэйгээр зохион байгуулж, улс орон бүрд энэ талаар тусламж, дэмжлэг үзүүлсээр ирсэн ба 2002 оноос хойш тогтмол 'Цахим засаглалын хөгжлийн индекс'-ийг үнэлэх мониторингийг дэлхийн бүх улс орныг хамруулан хийсээр байна. Хоёр жил тутамд гардаг энэ индексээр 2022 онд Дани Улс 0.9717 гэсэн үнэлгээтэйгээр тэргүүлж, Финлянд Улс 0.9533, БНСУ 0.9529 үнэлгээтэйгээр удаалжээ. Монгол Улсын хувьд 2016 онд 84, 2018 онд 92, 2020 онд 92 дугаар байрт эрэмбэлэгдэж байсан бол 2022 онд 0.7209 гэсэн үнэлгээгээр 74 дүгээр байранд эрэмбэлэгдэж, цахим засаглалын хөгжлийн индексээр 18 байр урагшилсан байна.

Монгол Улсад МХХТ ашиглан төрийн мэдээлэл, үйлчилгээг хүргэх үндэс суурь нь МУЗГ-ын МХХТ-ийн салбарт төрөөс баримтлах дунд хугацааны (2005-2012) стратеги, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд "Цахим Монгол" үндэсний хөтөлбөрийг 2004 онд баталснаар тавигдсан. Хөтөлбөрийн хүрээнд иргэндээ хандсан, нэг цэгийн, үр дүнтэй, хэмнэлттэй төрийн үйлчилгээг хөгжүүлэх зорилго дэвшүүлж, энэ зорилгыг хангахын тулд дэвшүүлсэн зорилтын нэг нь байгууллага бүр цахим хуудас, иргэн бүр цахим шуудангийн хаягтай болж, төрийн үйлчилгээг сүлжээгээр дамжуулан онлайн горимоор хүргэх явдал байв. Түүнчлэн МУЗГ-ын 2008 оны 143-р тогтоол "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийг баталж, төрийн байгууллагын ил тод байдлыг хангах тодорхой мэдээллийг албан ёсны цахим хуудсанд байршуулсан байхаар заасан нь төрийн мэдээлэл нийтэд нээлттэй байх үндэс суурь болсон юм. Тус журам 2011 онд "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль"-ийн Хоёрдугаар бүлэг болон батлагдаж, 2022 он хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

Энэхүү хуулийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор IRIM судалгааны хүрээлэн нь 2010-2011 онд төрийн цахим ил тод байдлыг хэмжих анхны арга зүйг боловсруулж, 2014 оноос хойш жил бүр тогтмол хэмжиж ирсэн. Хуулийн мониторингд суурилсан тус арга зүйг 2018 онд хүртэл хэрэглэж, 2019 онд шинэчлэн, эрх зүйн орчин болон байгууллагын чадамж гэсэн 2 бүрэлдэхүүн хэсэг шинээр нэмж, олон улсад ашиглагдаж болохуйц төрийн байгууллагын мэдээллийн “Цахим ил тод байдлын индекс”-ийг боловсруулж, анхны туршилтыг Монгол болон Киргизстан Улсад амжилттай туршиж байсан юм.

Сүүлийн жилүүдэд МУЗГ-аас цахим засаглалыг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг идэвхжүүлж, хариуцах шинэ бүтцийг бий болгож, дагалдах зарим томоохон бодлого, арга хэмжээг шинээр баталж, хэрэгжүүлж байна. Хийгдэж буй ажлуудыг авч үзвэл 2019 онд МУЗГ-аас “Цахим хөгжлийн үндэсний хороо”-г байгуулж, мөн иргэд төрийн мэдээллийг авах эрхийг хангасан “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсон. Тус хуульд өмнө нь мөрдөгдөж байсан хуулийн агуулгууд багтах аас гадна тухайн төрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран өөр нэмэлт мэдээллүүдийг тусгах шаардлагатай болсон нь илүү өргөн хүрээний мэдээлэлд мониторинг хийх шаардлагатай болсон. Түүнчлэн, хуульд мэдээллийг ‘нээлттэй’, ‘хязгаарлалттай’, ‘хаалттай’ гэж ангилсан нь зарим мэдээллийг ил тод болгох чадавх, процесст саад бэрхшээл учруулах эрсдэлтэйг үгүйсгэхгүй. Стратеги зорилтын хувьд 2021-2024 онд “Digital Nation” буюу “Цахим Үндэстэн” болох зорилтыг тавин ажиллаж байна. Мөн МУЗГ-аас 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлаж авлигатай тэмцэх Шүгэл ажиллагаа, Шүүр ажиллагаа, Шувуу ажиллагаа, Шилжүүлэн авах ажиллагаа, Шил ажиллагаа гэх таван үйл ажиллагааны хүрээнд төлөвлөгөө боловсруулан холбогдох талуудтай хамтран ажиллаж байна. Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас “Шилэн” ажиллагааг хариуцан хэрэгжүүлж, энэ

хүрээнд цахимжилтыг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хүнд суртлыг арилгах, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох зорилгоор дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Цахимжилтыг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хүнд суртлыг арилгах, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох;
- Төрийн өмчит компаниудыг олон нийтийн хяналттай, нээлттэй компани болгох, ур чадвар бүхий менежментийн багийг ажиллуулах;
- Улс төрийн намын хууль, эрх зүйн орчныг сайжруулж, улс төрийн болон улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, олон намын оролцоотой шударга өрсөлдөөнтэй, ардчилсан парламентын засаглалыг төгөлдөржүүлэх;
- Ёс зүйтэй, шударга өрсөлдөх орчныг бүрдүүлж, цэвэр, тунгалаг бизнесийг дэмжин хөгжүүлэх.

Төрийн байгууллагуудын мэдээллээ нээлттэй болгох үйл явц эрчимжиж, shilen.gov.mn платформыг 2023 оны гуравдугаар сарын 27-ны өдөр нээсэн бөгөөд “Таны төр-Та хяна” уриалгийг олон нийтэд дэвшүүлсэн. Уг платформ мэдээлэл хариуцагчдаас ирүүлсэн, хуулиар ил болгох ёстой мэдээллүүдийг нэгтгэн иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийнхэнд нэг цонхоор мэдээлэлд хяналт тавих боломжийг олгож байгаа юм. Энэ нь иргэдийн үндсэн хуулиар олгогдсон мэдээлэл авах эрхийг дэмжсэн нэн чухал ач холбогдолтой ажил хэрэгжүүлж байна.

2022 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль шинэчилсэн найруулга хийгдсэнтэй холбоотойгоор мэдээллийн цахим ил тод байдлыг хэмжих арга зүйд суурь шинэчлэлтүүдийг хийж өмнөх онд шинэ аргазүйгээр төрийн байгууллагуудын мэдээллийн цахим ил тод байдлыг үнэлсэн. Арга зүйн хувьд орсон өөрчлөлт нь ерөнхий хүрээг өөрчлөөгүй тул өмнөх онуудтай харьцуулах байдлыг алдагдуулаагүй юм.

1. Арга зүй

1.1. Индексийн зорилго, зорилт

Индекс нь төрийн байгууллагуудын мэдээллийн цахим ил тод байдлыг тоон үзүүлэлтээр хэмжиж, нийт үр дүнг улсын хэмжээнд тооцоолсноор цаашид Засгийн газар болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой. Энэ зорилгын хүрээнд дэвшүүлсэн мониторингийн гол зорилтууд нь:

- Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшнийг хэмжиж, эрэмбэлэх
- Үр дүнг өмнөх жилүүдтэй харьцуулах
- Цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах

Индексийн үр дүнд тулгуурлан байгууллага бүр өөрийн давуу болон сул талыг танин мэдэх боломжийг олгохын тулд харьцуулсан дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Цаашид уг индексийг байгууллагууд бие биеэсээ суралцах, цахим мэдээлэл түгээх чадавх болон сорилт, бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлийн бодлого, стратегийг тодорхойлох хэрэгсэл болгон ашиглахыг санал болгож байна.

Индексийн үр дүнг тооцон гаргахдаа дараах төрийн байгууллагуудыг жил бүр хамруулдаг (Зураг 1).

2021 онд эдгээр 6 төрлийн байгууллагын нийт тоо 88, 2022 онд 93 байсан бол 2023 онд 97 болж, өмнөх жилээс дөрвөөр нэмэгджээ. Энэ нь Хэрэгжүүлэгч агентлагийн тоо нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд байгууллагуудын чиг үүрэг улам нарийсаж, салбарлаж байгааг харуулж байна.

ЗУРАГ 1

Төрийн мэдээллийн цахим ил тод байдлыг тооцон гаргахад хамруулсан байгууллагууд



1.2. Индексийн хүрээ

Мэдээллийн цахим ил тод байдлыг тогтвортой хэрэгжүүлснээр авлигатай тэмцэх, засаглалыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Иргэд үнэн, зөв мэдээллийг хүлээн авснаар төрийн үйл ажиллагааг үр ашигтайгаар хянах, хариуцлага тооцох эрх мэдлээ хэрэгжүүлэх боломжтой. , Энэ нь ардчилал, хүний эрхийг сайжруулж, сайн засаглалыг бэхжүүлэх суурь итгэл үнэмшил болж өгдөг. Тиймээс иргэд төрдөө хяналт тавих, хариуцлага тооцох иргэдийн үйл ажиллагааны үндэс нь мэдээллийн эрх чөлөө юм.

Монгол Улсын 1974 онд соёрхон баталсан НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын фактын 19.2-т “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэсэн нь мэдээлэл авах эрхийн хүрээнд ямар асуудлууд багтахыг ерөнхийд нь тодорхойлжээ.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйл Монгол Улсын иргэний эдлэх үндсэн эрх, эрх чөлөөний 17-д төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэж заасан нь ардчилсан тогтолцоот улс болохын хувьд төрийн ил тод байдлыг хангах, иргэд төрийн мэдээллийг хүлээн авах эрх зүйн үндэс суурь болсон.

Төрийн оролцоог ил тод, нээлттэй байлгах үндсэн арга бол өөрийн санаачилгаар олон нийтэд мэдээллийг аль болох хүртээмжтэй болгох явдал бөгөөд үүнийг төрөөс мэдээлэл түгээх идэвхтэй арга гэж нэрлэдэг. Энэ нь хамгийн хэмжих боломжтой, чиг үүргийнх нь дагуу сайжруулах боломжтой суваг юм. Мэдээллийг түгээхдээ цахим хэрэгсэл ашиглах нь мэдээллийн дотоод эх сурвалж буюу мэдээлэгчийн мэдээлэл алдагдлыг хянах боломжтой болдог.

НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг ба Нийгмийн комисс: “Ил тод байдал гэдэг нь төрөөс гаргаж буй шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь уг шийдвэрийн нөлөөлж буй хэнд ч чөлөөтэй, хүртээмжтэй байхыг хэлнэ” гэж тодорхойлсон (UNESCAP 2011). Иймээс ч олон судалгаа, индексүүдэд ил тод байдал нь ил тод болсон мэдээллийн хэмжээ, цар хүрээтэй холбоотой байдаг. Гэсэн хэдий ч ил тод байдлын үндсэн ойлголт нь төрийн үйл явц өөрөө ил тод байх ёстой гэсэн үзэл санаанд оршдог.

Ил тод байдал нь хамтын ажиллагаанд тулгуурладаг: Төрийн албан хаагчид мэдээллийг нээлттэй болгох ёстой бөгөөд нөгөөтээгүүр мэдээллийг ашиглах шаардлагатай буюу боломжтой хүмүүс, бүлэг байх ёстой (Johnston M., 2004). Энэ үүднээс авч үзвэл мэдээллийн ил тод байдал нь эрэлт, нийлүүлэлт гэсэн талтай. Мэдээллийг ил тод болгох эрэлт гэдэг нь олон нийт, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл болон бусад оролцогч талуудад төрийн үйлчилгээ авах, шийдвэр гаргахад оролцох, төрийн үйл ажиллагаанд хяналт тавихад шаардлагатай мэдээллийн цогц юм. Мэдээллийн ил тод байдлын эрэлтийн талыг мэдээлэл авах эрх гэж өргөнөөр ойлгодог. Нөгөөтээгүүр, мэдээллийн ил тод байдлын хангагч тал гэдэг нь төрийн байгууллагуудын олон нийтийн хэрэгцээнд зориулан гаргаж буй мэдээллийн багц юм. Үүнийг бид ил тод байдал гэж үздэг. Харин мэдээллийг ил тод болгохдоо МХХТ ашиглан цахим хэлбэрээр нээлттэй, хүртээмжтэй хүргэхийг цахим ил тод байдал гэж тодорхойлж болно.

Дэлхийн банкнаас гаргасан өгүүлэлд мэдээлэл идэвхтэй түгээх нь цахим технологи бидний өнөөгийн амьдралд хүчтэй нөлөө үзүүлж буй эрин үед иргэдийн мэдэх эрхийг хангах ирээдүй хэмээн онцлон тэмдэглэсэн. Үүнд нөлөөлөгч дөрвөн хүчин зүйлсийг тэмдэглэсэн нь эрх зүйт ёс (rule of law), хариуцлагатай байдал (accountability), үйлчилгээний хүртээмж (access to services), оролцоо (participation) юм. Эдгээр

хүчин зүйлс тухайн төрийн байгууллага болон төрийн байгууллага хоорондын мэдээллийг өргөн хүрээнд идэвхтэй түгээхэд болон мэдээлэл хүсэх, хүлээн авах эрхийн аль алиныг нь дэмждэг давуу талтай.

Эдгээр тодорхойлолтоос үзвэл ил тод байдлыг бий болгох процесс нь мэдээллийг ил тод болгох үр дүн бус тасралтгүй үйл явц гэдэгт төвлөрч байгаа хэрэг юм. Өөрөөр хэлбэл төрөөс мэдээллийг ил тод болгох үйл явц нь зөвхөн төрийн үйл ажиллагааны үр дүн бус мэдээллийг ил тод болгох орчин бий эсэх, түүнийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын чадамж байгаа эсэх, үүний үр дүнд иргэд, олон нийтэд мэдээлэл бүрэн, хялбар, хүртээмжтэйгээр хүрч буй эсэх үйл явцыг үнэлэх юм. Тиймээс мэдээллийн цахим ил тод байдлыг хэмжих загвар нь мэдээлэл

авах эрхийг хангаж буй i) эрх зүйн орчин хэр бүрдсэн эсэх, ii) мэдээлэл өгөх үүрэг бүхий төрийн байгууллагын чадавх, iii) технологийн тусламжтай хүрч буй мэдээллийн агуулга нь иргэдэд бүрэн, цаг хугацаандаа хүрч чадаж байгаа эсэх зэрэг бүрэн цогцоор нь үнэлэх оролдлого юм.

Санал болгож буй индексээрээ бид төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдлыг хэмжих дараах гурван бүрэлдэхүүн хэсгийг танилцуулж байна.

Уг индекс нь зөвхөн тоон утгаар хэмжигдэж, ямар түвшинд байгааг тооцоолдог тул төрийн байгууллагуудын ил тод байдал яагаад буурч эсвэл нэмэгдэж байгаа талаар нарийвчилсан мэдээллийг өгөх боломж хязгаарлагдмал юм. Учир нь энэ ил тод байдлын түвшинд нөлөөлдөг хүчин зүйл болоод шинж

ЗУРАГ 2

Цахим ил тод байдлын индексийн хүрээ



Бодлогын орчин бүрэлдэхүүн хэсэг нь тухайн улс орны мэдээллийн ил тод байдлын эрх зүй, бодлогын орчныг үнэлнэ. Бодлогын орчны бүрэлдэхүүн хэсэг, түүнд харгалзах индикаторууд нь олон улсын, тухайн улсын, байгууллагын гэсэн гурван түвшинд үнэлэгдэхийн сацуу зарим салбарын шинжтэй үзүүлэлтүүдийг хамарна. Олон улсын түвшин дэх үзүүлэлтийг тодорхойлсон индикаторын дагуу олон улсын харгалзах индексүүдийн оноог хөрвүүлэх байдлаар авч ашиглана. Түүнчлэн, тухайн улс оронд төрийн байгууллагыг мэдээллээ ил тод, нээлттэй болгох нөхцөлийг хэрхэн хангаж байгаа талаар дэлгэрэнгүй авч үзнэ. Байгууллагын түвшинд эдгээр бодлого, журмыг хэрэгжүүлэхийн тулд өөрийн байгууллагадаа тохирсон дүрэм, журмыг баталж, мөрдүүлж байгаа эсэх, хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа эсэхэд анхаарах юм. Ихэнх тохиолдолд тухайн төрийн байгууллагын цахим ил тод байдлыг хангах процесс болон дүрэм, журам тодорхой байдаггүйгээс мэдээлэл хангалттай хэмжээнд ил тод болж чадахгүй байна. Тиймээс үүнийг бид бүхэн хэмжих оролдлогыг бодлогын орчны хэсэгт нэмж авч үзэх шаардлагатай болсон. 2022 оноос эхлэн ийнхүү байгууллага тус бүрд цахим мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгааг үнэлдэг болсноор байгууллага бүрийн бодлогын орчны үзүүлэлт ялгаатай үнэлэгдэх боломж бүрдсэн.

ЗУРАГ 3

Бодлогын орчныг үнэлэх түвшин



Байгууллагын чадамжийн бүрэлдэхүүн хэсэг нь тухайн төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдлыг хангах чадавхад чиглэгдэнэ. Өмнөх жилүүдэд манай байгууллагаас хийж ирсэн 'Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын мониторинг' нь мэдээллийн ил тод байдлыг хангах явдал нь тухайн байгууллагын чадавх, нөөцөөс ихээхэн хамаардаг болохыг харуулсан.

Төрийн байгууллагын цахим мэдээллийн ил тод байдлыг хангах чадамж нь дотоод дүрэм журмын тодорхой байдлаас гадна мэдээллийг ил тод болгох тодорхой үйл явц болон хүний нөөцийн чадавх, технологи ашиглах чадамж, технологи нь мэдээллийг ил тод болгоход хэр нийцтэй ажиллаж байгаа вэ гэдгээр тодорхойлогдоно.

2019 онд боловсруулагдсан эхний арга зүйгээр энэ хэсгийн үнэлгээг зөвхөн тухайн байгууллагын албан хаагчийн анхдагч мэдээлэлд тулгуурлан үнэлдэг субъектив шинжтэй байсан бол энэ нөлөөллийг багасгахыг зорьж, цахим хуудасны технологийн үзүүлэлтүүдийг илүү энэ хэсэгт авч үзэх болсон. Учир нь аливаа цахим хуудасны үзүүлэлтүүд нь тухайн байгууллагын технологийн чадамжийг харуулах нэг үндсэн үзүүлэлт мөн гэж үзсэн. Түүнчлэн байгууллагын мэдээллийг ил тод болгох үйл явц болон хүний нөөцийн чадавхыг үнэлэхдээ анхдагч болон хоёрдогч мэдээллийг хослуулсан хэлбэрээр авч үзэх юм.

Цахим нээлттэй мэдээлэл бүрэлдэхүүн хэсэг олон нийтийн мэдээлэл авах эрх хангагдаж байгаа эсэхэд (гарц) төвлөрөх ба 'Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль'-д заасан 'нээлттэй'-ээр байршуулахаар заасан мэдээллийн агуулгад төвлөрч, тус хуулийн:

- 8.8-д ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ **цахим хуудас**, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл **ашиглана**.
- 8.12.Мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран мэдээлэл хариуцагч **цахим хуудас**, мэдээллийн самбарыг **заавал ажиллуулах ба цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангана**.
- 8.13.Нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах тохиолдолд тус мэдээллийг өгөх эх сурвалжийг цахим хуудсанд тодорхой заасан байна зэрэг заалтуудад үндэслэн үр дүнг тооцно.

Ингэхдээ зөвхөн холбогдох хууль, журамд заасан мэдээллийг байгаа эсэхийг хэмжих бус цаг хугацааны нийцтэй байдал буюу заасан цаг хугацаандаа нийтэлсэн эсэхийг давхар хянах юм. Мөн хуульд заасан нээлттэй мэдээллийн цар хүрээг хэмжихээс гадна мэдээлэл авах эрхийг хангах, эрэлтийг бий болгоход чиглэсэн үйл явц буюу эгэх холбоо байгаа эсэх нь энэ бүрэлдэхүүн хэсгийн бас нэгэн гол үзүүлэлт юм. Тиймээс цаашид иргэд, олон нийттэй харилцах, мэдээллийг шуурхай түгээхэд онцгой ач холбогдолтой зарим индикаторуудыг энэ бүрэлдэхүүнд авч үзсэн.

1.3. Индексийн бүтэц ба хэмжих аргачлал

Ихэнх индексийн адилаар индикаторуудыг нэгтгэж, цахим ил тод байдлыг илтгэх нэгдсэн нэг оноогоор хэмжинэ. Индекс нь үндэсний болон байгууллагын түвшинд илэрхийлэгдэх боломжтой.

Индекс нь 3 гол бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 10 дэд бүрэлдэхүүн, 35 шалгуур үзүүлэлт, түүнийг тодорхойлох 150 асуулт/үзүүлэлтээс бүрдэнэ. Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу.

Цахим ил тод байдлын индексийг тооцохдоо өмнө нь эдгээр гурван бүрэлдэхүүн хэсэгт ижил жин хуваарилдаг байсан бол энэ удаа (i) бүрэлдэхүүн тус бүрийн индикаторыг хэмжих асуултын тоо болон (ii) ач холбогдлын зэргээс шалтгаалан ялгаатай жингээр тооцох арга зүйг ашигласан.

i. Цахим ил тод байдлын индексийн нийт 150 асуулт, Бодлогын орчны бүрэлдэхүүн 57, Байгууллагын чадамж бүрэлдэхүүн 29, Цахим нээлттэй мэдээлэл 64 асуулттай байна. Ингэснээр эдгээр дэд бүлгүүд тус бүр 0.13 (6/45), 0.8 (36/45) болон 0.07 (3/45) гэж жинлэгдэж байна. Жишээлбэл, эхний хүчин зүйлд Бодлогын орчны бүрэлдэхүүн хэсэг нийт үзүүлэлтийн хувьд 57 асуултаас бүрдэж байгаа учир 38% (57/150) жинтэй байна.

ii. Харин дараагийн хүчин зүйлд, бүрэлдэхүүн тус бүрийн ач холбогдлыг тэнцүү гэж үзэж байгаа тул 33.3% (1/3) байна.

Хэрвээ индикатор доторх асуултын тоо өөрчлөгдвөл эхний хүчин зүйлийн жинг дээрх аргаар хувааж тооцоолно. Тооцоолсон томьёог харуулбал:

$$DTI = \frac{1}{l} \sum_{k=1}^k \left(\frac{1}{3} \sum_{n=25} A_n + \frac{1}{3} \sum_{n=5} B_n + \frac{1}{3} \sum_{n=5} C_n \right)$$

k-Үндсэн нэмэгч индекс
l-Байгууллагын тоо
n-Индикаторын тоо

A- Эрх зүйн орчин
B- Байгууллагын чадамж
C- Цахим нээлттэй байдал

ХҮСНЭГТ 1

Хэмжих индикаторууд болон харгалзах оноо

Код	Индикаторууд	Дээд оноо
Е. Бодлогын орчин		57
E1	Мэдээлэл авах эрх (Олон улс)	8
E2	Засаглал (Олон улс)	12
E3	Иргэний нийгэм (Олон улс)	15
E4	Улсын түвшний бодлого, зохицуулалт	14
E5	Байгууллагын түвшний зохицуулалт	8
О. Байгууллагын чадамж		29
O1	Байгууллагын ил тод байдлыг хангах үйл явц ба нөөц	12
O2	Цахим хуудасны технологийн нийцтэй байдал	11
O3	МХТ-ийн чадавх	6
D. Цахим нээлттэй мэдээлэл		64
D1	Нээлттэй мэдээлэл	56
D2	Харилцаа холбоо ба эгэх холбоо	8
Нийт		150

Индексийн үр дүн нь 0-100-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 100 руу дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим ил тод байдал сайн, харин буурах тусам хангалтгүй байгааг харуулна. Цахим ил тод байдлын индексийн үр дүнгийн утгыг доорх зурагт нэгтгэн харууллаа.

ЗУРАГ 4

Индексийн үр дүнгийн утгын ангилал

Сайн	≥ 0.80	Цахим ил тод байдлыг бий болгох, мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бүрэн бэхжүүлсэн.
Хангалттай	0.65-0.79	Байгууллага мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бэхжүүлж байгаа.
Сул	0.50-0.64	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой зарим үзүүлэлт байгаа. Цаашид байгаа мэдээллүүдийг шинэчлэх, тогтвортой хангах чадавхыг бэхжүүлэх шаардлагатай.
Хангалтгүй	0.35-0.49	Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх талаар суурь түвшний процедур, нөөц, хариуцлагатай, ил тод байдлыг цаашид тогтвортой хангах чадвар хомс байна.
Муу	< 0.35	Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлага бараг байхгүй, энэ нь эргээд цахим хуудсаар мэдээллийг түгээхгүй байхад гол нөлөө үзүүлж байгаа.

2. Үр дүн

2.1. Нэгдсэн үр дүн

Төрийн болон орон нутгийн захиргааны 6 төрлийн 97 төрийн байгууллагын 2023 оны цахим ил тод байдлын ерөнхий индекс 65.2% гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индексийг хэмжиж эхэлснээс хойш анх удаа 'хангалттай' түвшинд үнэлэгдлээ. Уг үр дүнг 2022 онтой харьцуулахад (63.1%) бага зэрэг өссөн байгаа ч ангиллын хувьд нэг түвшин ахиж байгаа юм.

Нийт хамрагдсан төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшнийг ангилан харвал 55% нь 'хангалттай' болон 'сайн' түвшинд үнэлэгдэж. Харин үлдсэн 45% нь "сул" түвшинд үнэлэгдлээ. Өмнөх онуудад 'сайн' буюу 80%-аас дээш түвшинд цахим ил тод байдлаа хангасан байгууллага байгаагүй бол энэ жилийн хувьд хоёр байгууллага сайн түвшинд үнэлэгдсэн байна.

Эсрэгээр өмнөх онд 'хангалтгүй' түвшинд үнэлэгдсэн байгууллага 2% ийг эзэлж байсан бол энэ жилийн тухайд сул түвшинд үнэлэгдсэн


байгууллага байхгүй байна. Энэ нь төрийн цахим мэдээллийн ил тод байдлын түвшин дээшилж, жил ирэх бүрд байгууллагын мэдээллийн цахим нээлттэй байдал дээшилж буй илтгэж байна.

2.1.1. Цахим ил тод байдлын өөрчлөлт

IRIM судалгааны хүрээлэн нь 2010 оноос эхлэн төрийн байгууллагын цахим мэдээллийн ил тод байдлыг хэмждэг болсон ба 2014 оноос хойш тасралтгүй хэмжсээр өдгөө 10 дахь жилдээ тасралтгүй үнэлж байна. 2018 он хүртэл зөвхөн цахим хуудсанд үнэлгээ хийж, ил тод байдлыг "Хаалттай", "Зарим талаар ил тод", "Ил тод", "Бүрэн ил тод" гэсэн 4 түшингээр үнэлдэг байсан бол 2019 оноос эхлэн 'Мэдээллийн цахим ил тод байдлын индекс'-ийн арга зүйг боловсруулан шинээр хоёр үндсэн бүрэлдэхүүн нэмэн, тус бүрийг өөр өөр эх сурвалжаас мэдээлэл авдаг болж, одоогийн 5 түвшнээр үнэлдэг болсон. Гэхдээ өмнөх онуудын үр дүнтэй харьцуулах боломжтой ба дараах дүрсэд нэгтгэсэн үр дүнг


ЗУРАГ 5

Байгууллагуудын ил тод байдлын түвшинд эзлэх хувь



ЗУРАГ 6

Цахим ил тод байдлын өөрчлөлт, оноор



Сайн | >80 Хангалттай | 65-79 Сул | 50-64 Хангалтгүй | 35-49 Муу | <35

харуулж байна. 2015 онд цахим мэдээллийн ил тод байдал 'хангалтгүй' түвшнээс 'сул' түвшинд ахисан бол 8 жилийн дараа 'сул' түвшнээс 'хангалттай' түвшинд үнэлэгдлээ.

Энэ жилийн үнэлгээ нь Нийтийн мэдээллийн тухай хууль шинээр батлагдаж, хэрэгжсэнээс хойш 2 дах удаагаа хийгдэж буй үнэлгээ бөгөөд өмнөх онтой харьцуулахад индексийн түвшин 2%-аар өссөн нь бага хэмжээний өөрчлөлт хэдий ч цахим ил тод байдлын ангиллын хувьд нэг шат ахисан үзүүлэлт гэдгийг онцлох нь зүйтэй. Үнэлгээний ажлыг хэрэгжүүлснээс хойш арван хоёр жилийн хугацаанд төрийн байгууллагуудын цахим хуудасны мэдээллийн агуулга, хүртээмж бага багаар сайжирдаг боловч зарим жилүүдэд доогуур үнэлэгддэг. Үүнийг он цагаар нь тодруулан харвал сонгууль болж, Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орсноор цахим ил тод байдалд нөлөө үзүүлдэг нь ажиглагдсан. Мэдээллийн цахим ил тод байдлын индекс 2023 оны үзүүлэлт 'хангалттай' түвшинд хүрэхэд бодлогын орчин болон байгууллагын чадамж

хэсгийн үнэлгээ өмнөх онтой харьцуулахад өсөж ангиллын хувьд 'хангалттай' түвшинд очсон нь нөлөөлсөн. Харин цахим нээлттэй мэдээлэл 'сул' түвшинд хэвээр байгаа бөгөөд төрийн байгууллагууд цахим хуудсан дээрх мэдээллээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 60 гаруй төрлийн мэдээллийг бүрэн нээлттэй болгох шаардлагатай хэвээр байна.

2.2. Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн

Өмнөх хэсэгт дурдсанчлан энэхүү тайлан нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль шинэчлэгдэж гарснаас хойш хийгдэж буй хоёрдох удаагийн үнэлгээ юм. Өнгөрсөн жилийн хувьд арга зүйд шинэчлэл орж хууль хэрэгжиж эхэлснээс хойших суурь үр дүнг гаргаж байсан учир энэ жилийн үнэлгээг суурь үр дүнтэй харьцуулах боломжтой болсон.

ЗУРАГ 7

Цахим ил тод байдлын нэгдсэн үр дүн, бүрэлдэхүүн тус бүрээр



¹ Бүрэлдэхүүн тус бүрийн индекс дэд бүрэлдэхүүний нийлбэрээр тодорхойлогдоно.

2.2.1. Мэдээллийн ил тод байдлын олон улсын харьцуулалт

Энэ хэсэгт Монгол Улс-ын мэдээллийн цахим ил тод байдлыг бүс нутаг болон олон улсын түвшинтэй харьцуулахыг зорьсон. Ингэснээр мэдээллийн цахим ил тод байдлын индексийн ялгаатай, онцлог байдлыг ойлгоход тусална. Мэдээллийн цахим ил тод байдлын индексийн зарим бүрэлдэхүүн хэсгүүдийг олон улсад ашиглагддаг цахим ил тод байдлын ижил төстэй элементүүдийг хэмждэг янз бүрийн индексүүдтэй харьцуулав. Арга зүйн болон индексүүдийн ялгаатай байдлаас үүдэн мэдээллийн цахим ил тод байдлын индексийг бүхэлд нь бусад улс орны индексүүдтэй шууд харьцуулах боломжгүй хэдий ч зарим голлох үзүүлэлт болон ойлголтуудыг харах боломжтой. Эдгээр харьцуулж буй индексүүдийн ихэнх нь мэдээллийн цахим ил тод байдлын индексийн бодлогын орчны индекс тооцох гол эх сурвалж болдог гэдгийг тодотгох нь зүйтэй. Олон улсад бодлогын элементүүдийг хэмждэг хэд хэдэн ижил төстэй индексүүд байдаг. Нэгдүгээрт, НҮБ-ын Цахим Засаглалын Хөгжлийн Индекс (ЦЗХИ 2022)-ийн задаргаагаар үр ашигтай харьцуулалт хийх боломжийг олгодог.

Цахим ил тод байдлын индексийн бодлогын орчны бүрэлдэхүүн хэсэг нь ЦЗХИ-ийн Цахим Үйлчилгээний Индексийн Байгууллагын Тогтолцооны дэд бүрэлдэхүүн хэсэгтэй харьцуулалт хийхэд бүрэн нийцдэг. Цахим үйлчилгээний индексээр МУ дэлхийд 79 дүгээрт эрэмбэлэгдсэн байна. Гэсэн хэдий ч, цахим мэдээллийн ил тод байдлын индекстэй шууд хамааралтай Байгууллагын Тогтолцооны дэд бүрэлдэхүүн хэсгээрээ МУ 0.9615 (0-ээс 1-ийн хооронд) оноо авсан. Энэ нь олон улсын тархалттай харьцуулахад харьцангуй өндөр оноо бөгөөд бүс нутгийн хэмжээнд Хятад, Япон, Өмнөд Солонгос, Сингапур зэрэг улс орнуудтай жингээрээ (бүгд 1 оноотой) ойролцоо байгаа юм.

Өөр нэгэн харьцуулалтад ашиглагддаг индекс бол Дэлхийн Шударга Ёсны Төсөл (ДШЁТ 2023), Улс орнуудын Хуулийн Засаглалын Индекс (ХЗИ) юм. Монгол Улс ХЗИ-ийн Зохицуулалтын хэрэгжилтийн хүчин зүйлээр дэлхийд 79-

д, бүс нутагтаа 15 орноос 10-д, ижил төстэй орлоготой 37 орны 12-т эрэмбэлэгдсэн байна. Энэхүү үзүүлэлт нь “эрх зүйн зохицуулалтуудыг хэр шударга, үр дүнтэй хэрэгжүүлж, мөрдүүлж” (ДШЁТ 2023) байгааг хэмждэг. Үүнээс харахад Монгол Улс эдгээр үзүүлэлтүүдээрээ дэлхийд дундаж түвшинд эрэмбэлэгдэж байгаа хэдий ч ижил төстэй орлоготой улс орнуудтай харьцуулахад эхний 25-30%-д багтаж байна.

ХЗИ-ийн Нээлттэй засаглалын хүчин зүйл нь мөн ач холбогдол бүхий харьцуулалт хийх боломжийг олгодог. Нээлттэй Засаглал гэдэг нь “Засгийн газрын мэдээлэл солилцоо, хариуцлагатай байдал болон төрийн бодлогыг хэлэлцэхэд иргэдийн оролцоог ямар хэрэгслээр хэр зэрэг хангаж буй байдал зэргээр засгийн газрын нээлттэй байдлыг хэмжинэ” (ДШЁТ 2023). Нэн ялангуяа Мэдээлэл авах эрх, харилцаа холбоо, хариуцлагын дэд бүрэлдэхүүн хэсэгтэй давхцаж байгаа юм. Монгол Улс Нээлттэй засгийн газрын үзүүлэлтээр дэлхийд 74-т (бүсийн хэмжээнд 15 улсаас 8 дугаарт, 37 ижил орлоготой улсуудаас 9-т) эрэмбэлэгдэж байна. Иймд Монгол Улс орлогын бүлгээрээ дунджаас дээгүүр, бүс нутгийн хэмжээнд ойролцоогоор дундаж түвшинд багтаж байгааг ХЗИ-ийн үр дүнгээс харж болно.

Цахим мэдээллийн ил тод байдлын индексийн Мэдээлэл авах эрхийн дэд бүрэлдэхүүн хэсгийг Хууль, ардчиллын төвийн Мэдээллийн эрхийн индекс (МЭИ) (МЭИ 2023)-тай харьцуулж болно. МЭИ-ээр Монгол Улс дэлхийд 68-т эрэмбэлэгдэж байгаа бөгөөд мөн л дундаж түвшинд багтаж байна. Гэсэн хэдий ч энэхүү бүрэлдэхүүн хэсгийн эрэмбээр АНУ (76-т) болон Норвеги (92-т) зэрэг чинээлэг хөгжилтэй улс орнуудаас дээгүүр байр эзэлж байна. Бүсийн түвшинд, БНСУ (46-т), Индонези (41-т) улсууд дээгүүр байр эзэлж байгаа боловч Монгол Улс нь Япон (85-т), Хятад (90-т), Казакстан (117-т) болон Вьетнам (87-т) зэрэг улс орнуудаас дээгүүр эрэмбэлэгджээ. Үүнээс үзэхэд мэдээлэл авах эрхийн тухайд Монгол улсын цахим мэдээллийн ил тод байдал бүс нутаг болон дэлхийн түвшинд харьцангуй сайн гэж дүгнэж болохоор байна.

Цахим мэдээллийн ил тод байдлын хоёр дахь бүрэлдэхүүн хэсэг болох Байгууллагын чадавхыг

харвал Технологийн чадавх болон Мэдээлэл харилцаа, холбооны Технологи (МХХТ)-ийн чадавх зэрэг дэд бүрэлдэхүүн хэсгүүдийг ЦХИ-тэй, нэн ялангуяа Харилцаа холбооны дэд бүтцийн индексийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй харьцуулалт хийж болно. Хоёр индексийн харьцуулалтын хувьд хэмжигдэхүүнүүд нь ялгаатай учир зарим үзүүлэлтүүд нь хоорондоо нийцэхгүй гэдгийг онцлох нь зүйтэй юм.

ЦЗХИ нь ерөнхийдөө Цахим засаглалыг хөгжилд чиглэдэг бол Цахим мэдээллийн ил тод байдлын индекс нь Цахим засаглалын ил тод байдалд илүү анхаарал хандуулдаг онцлогтой. Гэсэн хэдий ч, хоёр индексийн эдгээр дэд бүрэлдэхүүн хэсгүүд нь дэд бүтцийн чадавхыг хэмжихийг оролдож байгаа тул цахим мэдээллийн ил тод байдлын индекс болон ЦЗХИ-ийн аль алиных нь талаар ач холбогдолтой ойлголтыг авч болно. Монгол Улс Харилцаа холбооны дэд бүтцийн индексээр 0.6973 (хамгийн дээд тал нь 1) оноо авч дэлхийн 193 орноос 74-т жагссан. Орлогын бүлэгтэй нь харьцуулбал, дунджаас доогуур орлоготой 51 орноос Монгол Улс Харилцаа холбооны дэд бүтцийн индексээр 3-т эрэмбэлэгдсэн байна. Бүсийн хэмжээнд, Монгол Улс Азийн бүсийн 40 орноос 18-д жагсжээ. (Энэ индекст Ази тивд Ойрхи Дорнод, Турк, Өмнөд Ази багтсан болно). Эдгээр үр дүн нь дээр дурдсан бусад дүгнэлттэй нийцэж байгаа бөгөөд Монгол Улс дэлхийд ойролцоогоор дундаж түвшинд байр эзэлж байгаа боловч орлогын бүлэгтэй харьцуулахад дунджаас дээгүүр түвшинд багтаж байна.

ЦЗХИ-ийн Цахим Оролцооны Индексийн бүрэлдэхүүн хэсгийг Цахим мэдээллийн ил тод байдлын индексийн Цахим Ил Тод Байдлын бүрэлдэхүүн хэсэгтэй харьцуулж болно. Гэсэн хэдий ч, ЦЗХИ-ийн хамрах хүрээ нь Цахим Ил Тод байдлын индексээс хамаагүй өргөн хүрээтэй тул нэг бүрчлэн харьцуулах боломжгүй гэдгийг дахин онцолж байна.

Монгол улс Цахим Оролцооны Индексээр 0.6023 оноогоор дэлхийд 60-т, дунджаас доогуур орлогын бүлгийн 51 улсаас 5 дугаарт тус тус эрэмбэлэгдэж байна. Эдгээр үзүүлэлт нь дээр дурдсан бусад үр дүнтэй нэгэн адил Монгол улс орлогын бүлгээрээ дунджаас хамаагүй дээгүүр байгааг харуулж байгаа хэдий ч Цахим ил тод

байдлын индексээр Монгол Улсын Цахим нээлттэй байдлын гүйцэтгэл 45.6% тай буюу “хангалтгүй” түвшинд үнэлэгдсэн. Энэхүү зөрүү нь хоёр индексийн цахим ил тод байдлыг ялгаатай үзүүлэлтүүдээр хэмжиж байгааг харуулж байгаа юм.

Ерөнхийдөө, Цахим мэдээллийн ил тод байдлын индексийг бусад индексүүдтэй харьцуулах нь янз бүрийн арга зүй, ялгаатай чиглэлүүдээс үүдэн бэрхшээлтэй ч цахим ил тод байдлын индексүүдийг задалж, түүний дэд бүрэлдэхүүн хэсгүүдийг холбогдох олон улсын хэмжигдэхүүнүүдтэй харьцуулахад чухал ойлголт, үр дүнгүүдийг харж болохоор байна. Тухайлбал, дээрх үр дүн, хандлагаас харахад Монгол Улс дэлхийд дунд түвшинд байгаа бол орлогын бүлгээрээ дунджаас дээгүүрт багтаж байна.

Дээр дурдсан олон улсын бусад индексүүдтэй харьцуулахад Мэдээллийн Цахим Ил Тод Байдлын Индексийн нэг чухал давуу тал нь байгууллагын түвшинд хүчин зүйл тус бүрээр үнэлдэг явдал юм. Түүнчлэн Монгол Улсыг бүхэлд нь үнэлэхээс гадна яамд, тохируулагч агентлагууд, орон нутгийн засаг захиргаа, парламентын харьяа байгууллагууд, засаг захиргааны нэгж, хэрэгжүүлэгч агентлагуудын мэдээллээр хангадаг.

Мэдээллийн цахим ил тод байдлын индексийн арга зүй нь байгууллагын түвшний нарийвчилсан мэдээллийг гаргадаг давуу талтай. Жил бүр мэдээллийн цахим ил тод байдлын индексийг мониторингийг давтан хийснээр шинэ дата мэдээлэл цуглуулж динамик үр дүнгүүд гаргадаг бөгөөд эдгээр нь бодлого боловсруулагчдад Монголын цахим мэдээллийн ил тод байдлын элементүүдийг байгууллагын түвшинд ойлгох, хянах, сайжруулахад онцгой ач холбогдолтой.

2.2.2. Мэдээллийг ил тод болгох бодлогын орчны нөхцөл байдал

Мэдээллийн цахим ил тод байдлыг хэрэгжүүлэх, сайжруулахад бодлогын орчны дэмжлэг, тогтолцоо суурь шинжтэй буюу тэргүүлэх ач холбогдолтой тул үүнийг хангахад бодлогын орчныг хэр бүрдүүлсэн бэ гэдэгт анхаарах нь зүйтэй. Бодлого, зохицуулалтын орчны ил тод байдлыг ханган ажиллах боломж нөхцөлийг хэр хангасныг олон улс, үндэсний болон байгууллагын түвшинд нарийвчлан үнэлсэн. Энэ бүрэлдэхүүн хэсгийн үр дүнг өмнөх хэсэгт авч үзсэн олон улсын түвшинд гарч буй засаглалын ил тод байдлын үзүүлэлтүүд болон үндэсний ба байгууллагын түвшинд мэдээллийн цахим ил тод байдлыг хангах чиглэлээр батлан хэрэгжүүлж буй бодлого, журамд үндэслэн индекс тооцдог.

Бодлогын орчин 'хангалттай' (79.2%) түвшинд үнэлэгдсэн. Энэ үр дүнг 2022 оны үр дүнтэй харьцуулахад (78.8%) бага зэрэг өссөн үзүүлэлт юм. Бодлогын орчин өмнөх жилээс 0.4 хувиар өссөн байдлыг бодлогын орчинд хамаарах дэд 5 бүлгээр задлан үзэхэд бүгд ахисан үзүүлэлттэй байна. Энэ нь 2022 оноос шинэ хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 онд байгууллагуудын шинэ хуулийн дагуу нийцүүлэн гаргасан дотоод дүрэм журмын шинэчлэл хийгдэх үйл явц үргэлжилж байгаа нь эерэг үр дүн гарахад нөлөөлсөн байна. Бодлогын орчны үнэлгээг дэд бүрэлдэхүүн тус бүрээр задлан харвал дараах үр дүн харагдаж байна.

Олон улсын түвшний үзүүлэлтүүдийг Мэдээлэл авах эрх, Засаглал, Иргэний нийгэм гэсэн гурван дэд бүрэлдэхүүний хүрээнд (i) энэ чиглэлд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, (ii) Монгол Улс хамрагдсан хамруулан 10 индексээс эх сурвалж болгон үр дүнг тооцсон. Үр дүнд Монгол Улсын цахим ил тод байдлыг үнэлж буй олон улсын индексүүд "хангалттай" түвшинд үнэлж байна.

Олон улсын индексүүдийн 2023 онд шинэчлэгдсэн үр дүнг авч үзвэл Rule of Law Index-ийн хүрээнд 142 улсаас 0.53 оноогоор 64 дүгээрт, Freedom House Index -д 210 улсаас 84 оноогоор 55 дугаарт, World Press Freedom Index-д 180 улсаас 59.33 оноогоор 88 дугаар байр тус тус эрэмбэлэгджээ. Өмнө 2022 онд харьцуулахад Rule of Law Index-д 62 дугаар байрнаас 64 дүгээр байрт буюу 2 байр ухарсан бол Freedom House Index -д 55 дугаар байраа хадгалсан байна. Харин World Press Freedom Index-д 90 дүгээр байрнаас 88 дугаарт байрт орж хоёр байр урагшилжээ. Ашигласан эх сурвалжийн хураангуйг Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2

Бодлогын орчны индекс

Дэд бүрэлдэхүүн	2022 оны индекс	2023 оны индекс	Өөрчлөлт
Бодлогын орчин	78.8%	79.2%	+0.4%
Олон улс			
Мэдээлэл авах эрх	26.0%	27.0%	+1.0%
Засаглал	18.0%	16.0%	+2.0%
Иргэний нийгэм	23.2%	23.0%	-0.2%
Улс			
Үндэсний бодлого, зохицуулалт	10.8%	12.0%	+1.2%
Байгууллага			
Байгууллагын бодлого зохицуулалт	0.9%	1.2%	+0.3%

² Бодлогын орчны бүрэлдэхүүний оноо дэд бүрэлдэхүүн тус бүрийн нийлбэрээр тодорхойлогдоно.

ХҮСНЭГТ 3

Бодлогын орчны хүрээнд хамруулсан олон улсын индексүүд

Индексүүд	Гаргасан байгууллага	Гарсан он	Монгол Улсын эрэмбэ	Хамрагдсан улсын тоо
Right to Information (RTI) Rating	Centre for Law and Democracy	2018	64	135
Rule of Law Index	World Justice Project	2023	64	142
World Governance Indicators (WGI)	World Bank	2022	46	214
Bertelsmann Transformation Index (BTI)	Bertelsmann Stiftung	2022	26	137
Freedom House Index	Freedom House	2023	55	210
Global Civic Engagement	Gallup	2016	25	140
World Press Freedom Index	Reporters without borders	2023	88	180
Varieties of Democracy (V-Dem)	V-Dem Institute	2022	121	179
Global Indicators of Regulatory Governance	World Bank	2018	56	187
E-Government Development Index	United Nations	2022	74	193

Үндэсний түвшний дэд бүрэлдэхүүнд Монгол Улсын урт болон дунд хугацаанд баримтлах хөгжлийн баримт бичиг, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой батлагдсан хууль, тогтоомж болон түүнийг даган гарсан журмуудыг хамруулан авч үзсэн.

Үр дүнд нь эдгээр баримт бичгүүдэд мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой агуулга 'хангалттай' орсон боловч зохицуулалтын орчин тодорхойгүй байна. Тэр дундаа мэдээллийг ил тод болгож буй үйл ажиллагаанд хяналт тавих, сайжруулах механизм дутагдалтай хэвээр байна. Дэлгэрүүлбэл, урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд тус бүрдээ энэ төрлийн агуулгыг зорилт хэлбэрээр тодорхойлж, хоорондын уялдаа сайтар хангагдсан.

Шинээр мөрдөгдөж буй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар тодорхой түвшинд мэдээллийн ил тод байдлыг сайжруулах алхмууд хийгдсэн боловч энэ чиглэлийн зарчмуудыг хангах, хуулийн зохицуулалт бүрэн тодорхой байх үзүүлэлтүүдийн хүрээнд сайжруулах орон зай цаашид тулгарч байна. Харин уг хуулийг даган гарахаар тодорхойлогдсон 12 журмын хүрээнд хэмжих үзүүлэлтүүд хяналт тавих механизмаас бусад нь маш сайн хангагдсан байна. Байгууллагын түвшний дэд бүрэлдэхүүнд мэдээллийн ил тод байдлыг хангах байгууллагын дотоод зохицуулалттай холбоотой 8 үзүүлэлтээр үнэлэхэд 97 байгууллагаас 57 байгууллага нь буюу 59% нь мэдээлэл авах эрхийг хангах хууль, түүнийг даган гарсан журмуудын хүрээнд

байгууллага дотооддоо зохицуулалтаа хангах баримт бичиггүй буюу албан ёсны цахим хуудастаа байршуулаагүй байна. Үлдсэн 40 байгууллагын хувьд дотоод зохицуулалт бүхий баримт бичигтэй цахим хуудсандаа байршуулсан хэдий ч хэрэгжүүлэх субъектийг тодорхойлох, боломжит нөөцөөр хангах болон хяналт тавих механизмын талаарх агуулга тусаагүй байна.

Байгууллагын түвшинд дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд цахим мэдээлэл болон мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой заалт дийлэнх байгууллагад туссан боловч ерөнхий байдлаар тусгажээ. "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-н зохицуулалттай холбоотойгоор дотоод журмаа сүүлийн жилүүдэд шинэчилсэн, хууль болон дагалдах журамуудад дурдсан агуулгууд бүрэн орж тусгагдсан болоод мэдээллийн ил тод байдлыг хангах дотоод үйл явцын тогтвортой байдлыг хангах үзүүлэлтүүдийн хүрээнд үнэлэхэд 6.2% нь л эдгээр агуулгуудыг хангалттай түвшинд тусгасан байна. Энэ ердөө 6 байгууллага бөгөөд эдгээр нь:

1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар,
2. Үндэсний статистикийн хороо,
3. Гадаад харилцааны яам,
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар,
5. Архивын ерөнхий газар
6. Ойн газрын журмууд байв.

Энэ үр дүнг өмнөх жилтэй харьцуулахад нэмж хоёр байгууллага мэдээллийн ил тод байдлыг хангах тай холбоотой журмыг шинээр батлан, нийтэлсэн гэсэн үг юм.

Мэдээллийн цахим ил тод байдлыг хангах талаар байгууллагууд дотооддоо дүрэм, журам, тушаал гаргахдаа мэдээллийн цар хүрээг тодорхойлох, мэдээллийг ангилах, мэдээллийг бэлтгэх, хариуцагчийн тодорхойлох, нийтлэгчдийн эрх, үүргийг тодорхойлж шинэчлэгдэх хугацаа болон хэрэгжилтэд хяналт тавих механизмыг тодорхой тусгах нь үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.2.3. Төрийн байгууллагын мэдээллийг ил тод болгох чадамж, бэлэн байдал

Ил тод байдлыг хангахын тулд мэдээллийг нийлүүлэгч буюу тухайн байгууллагын мэдээллийн тасралтгүй үйл явцыг хангах чадамж, бэлэн байдал нь чухал үүрэгтэй. Иймд энэ бүрэлдэхүүн хэсэг нь мэдээллийг ил тод болгох хүний нөөцийн чадавх, бэлэн байдал, МХХТ-ийг ашиглах чадавх болон цахим хуудасны стандарт шаардлагуудад нийцсэн эсэхэд анхаарал хандуулдаг. Энэ бүрэлдэхүүн хэсгийн мэдээллийн эх сурвалж нь (i) үнэлгээнд хамрагдаж буй тухайн төрийн байгууллагын холбогдох ажилтнаас авдаг анхдагч мэдээлэл, (ii) цахим хуудасны технологийн нийцтэй байдлыг илтгэх үзүүлэлтүүд юм. 2019-2021 он хүртэл энэ бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээг бүхэлд нь тухайн байгууллагын ажилтнаас авсан мэдээлэлд үндэслэдэг байсан нь субъектив шинжтэй, мэдээлэл авч чадаагүй тохиолдолд энэ хэсгийн индексийг бүхлээр нь тооцох боломжгүй болдог байсан сул талыг багасгаж, сүүлийн хоёр жилд тодорхой үзүүлэлтийг тооцох боломжтой болсноороо онцлогтой.

Байгууллагын чадамж 'хангалттай' (72.8%) түвшинд үнэлэгдсэн. Энэ нь өмнөх оны үр дүнтэй харьцуулахад мэдэгдэхүйц өссөн үзүүлэлт юм. Энэ нь төрийн байгууллагын цахим мэдээллийн ил тод байдлын индекс 'сул' түвшнээс 'хангалттай' түвшинд үнэлэгдэхэд чухал нөлөө үзүүлсэн байна. Байгууллагын

чадамж хэсгийн үзүүлэлтийн өсөлтийг дараах шалтгаануудаар тодорхойлов.

Байгууллагын чадамж хэсгийн үзүүлэлтийн өсөлтийг дараах шалтгаануудаар тодорхойлов. Үүнд:

- Байгууллагын чадамж хэсгийн зарим үзүүлэлтийг тооцох зорилгоор тухайн байгууллагын ил тод байдал хариуцсан мэргэжилтнээс авдаг судалгаанд байгууллагууд жил ирэх бүрд идэвхтэй хамрагддаг болсон. 2021, 2022 онд 70 байгууллага энэ судалгаанд хамрагдсан бол 2023 онд энэ тоо 86 болж өссөн.
- 2022 онд нийт судалгаанд хамрагдсан байгууллагын 38% нь мэдээллийн цахим ил тод байдлыг бий болгох стратегийн төлөвлөгөө/хөтөлбөртэй гэж өөрсдийгөө дүгнэсэн бол 2023 онд 48% нь ийм төрлийн хөтөлбөр байгаа гэж хариулсан байна.
- Цахим хөгжил, харилцаа холбооны яам (ЦХХХЯ)-тай болсноор мэдээллийг ил тод байлгах чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудад чадавхжуулах сургалтууд өгч, байгууллагуудаас энэ чиглэлийн сургалт авах боломж өнгөрсөн онтой харьцуулахад өссөн гэдгийг судалгаагаар дурдаж байв.

Үүнийг бүрэлдэхүүн тус бүрээр задлан харвал дараах үр дүн харагдаж байна.

Хүснэгт 4

Байгууллагын чадамж хэсгийн дэд бүрэлдэхүүний индекс

Дэд бүрэлдэхүүн	2022 оны индекс	2023 оны индекс	Өөрчлөлт
Байгууллагын чадамж	66.2%	72.8%	+6.6%
Байгууллагын ил тод байдлыг хангах үйл явц ба нөөц	40.1%	41.1%	+1.0%
Цахим хуудасны технологийн нийцтэй байдал	10.5%	15.9%	+5.4%
Мэдээлэл, харилцааны технологийн чадавх	15.5%	15.8%	+0.3%

³ Байгууллагын чадамжийн бүрэлдэхүүний оноо дэд бүрэлдэхүүн тус бүрийн нийлбэрээр тодорхойлогдоно.

Нийт үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын 65.8% нь мэдээлэл ил тод болгох үүрэг бүхий хариуцсан ажилтан болон алба, нэгжтэй, 29.3% нь энэ үүргийг хавсран гүйцэтгэдэг, 4.9% нь мэдээллийг ил тод болгох үүрэгтэй ажилтан байхгүй эсвэл байгаа эсэх нь тодорхойгүй байна. Жил ирэх бүрд хариуцсан ажилтан болон алба нэгжийн тоо нэмэгдэж байгаа нь сайшаалтай зүйл юм.

Өмнөх онд мэдээллийг ил тод болгохтой холбоотой төсөв, хөрөнгө төрийн байгууллагуудын 50%-д нь тодорхой хэмжээнд суулгадаг гэж хариулж байсан бол энэ жилийн хувьд 62% болж өссөн байна. Гэвч тухайн төсөв нь хүрэлцээгүй байдаг гэж дийлэнх хэсэг нь үзсэн бөгөөд энэ онд ч мөн ялгаагүй 71% нь хүрэлцдэггүй гэж үзсэн.

Байгууллагын чадамж хэсэгт 2023 онд онцгой анхаарах зүйлсийн нэг нь төрийн байгууллагууд мэдээллийн цахим ил тод байдлыг бий болгох дотоод төлөвлөгөө, стратегийг тал хувь нь бий болгосон явдал байлаа. Гэвч тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг талаас бага хувь нь л төлөвлөгөөний дагуу бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлдэг гэж дүгнэсэн байна.

Байгууллага бүрд жил бүр хамгийн бага гардаг үзүүлэлт бол цахим ил тод байдлынхаа гүйцэтгэлийг тогтмол хянаж, үнэлэх явдал юм. Энэ нь байгууллагын улирал болон жилийн эцсийн үнэлгээнд мэдээллийн цахим ил тод байдлыг бий болгохтой холбоотой үнэлгээ тусгагдаагүй, гүйцэтгэлийг үнэлэх ямар нэг шалгуур үзүүлэлт стратегитай хамт баталж хардаггүйтэй холбоотой хэмээн дурдаж байв. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомжууд цахим хуудсанд байршсан эсэх дээр мэдээллийг ил тод болгох, цахим засаглалыг бий болгохтой холбоотой дүрэм журам, баримт бичгүүд цөөн хэдэн байгууллагын цахим хуудсанд байршиж байгаа нь ажиглагддаг.

Дараагийн нэг анхаарах асуудал нь цахим хуудасны мэдээллийн шинэчлэл хэсэг юм. Нийт байгууллагын 90-с дээш хувь нь цаг үеийн шинэ мэдээ, мэдээллийг тогтмол оруулж байгаа нь сайшаалтай хэдий ч хүний нөөцийн мэдээллүүд шинэчлэгддэггүй, шинэчлэлийг

харуулсан баримт байдаггүй. Тухайлбал, мониторингийн хүрээнд төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэнтэй уулзах өрөөний тоот болон дугаарыг аваад холбогдох үед тухайн байгууллагад ажиллахаа больсон эсвэл өөр албан тушаалд очсон гэсэн хэд хэдэн тохиолдол гарав.

МТХ-ын болон цахим мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлийн сургалтууд авах боломжтой байдаг гэж өмнөх онд нийт байгууллагын ердөө 8% нь хэлж байсан бол энэ онд 26% нь энэ чиглэлийн сургалт авах боломжтой гэж үзжээ. Энэ чиглэлийн сургалтыг Цахим хөгжил, харилцааны холбооны яамнаас зохион байгуулсан тухай сургалтад хамрагдсан гэж хариулсан ажилтнуудын дийлэнх хувь нь хариулсан байна. Цахим ил тод байдлыг бий болгох яамтай болсон нь МТХ-ын сургалт авах боломжтой гэж үзсэн оролцогчийн тоо өсөхөд нөлөөлсөн үзүүлэлт юм. Учир нь 2023 оны 4-р сард ЦХХХЯ-ны Салбарын хяналтын газар, “Шилэн” ажиллагааны хүрээнд “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтийг мэдээлэл нь хаалттай, хэрэгжилт хангалтгүй төрийн байгууллагуудаас шаардаж, хэд хэдэн газруудад хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Цахимаар иргэдийн санал зөвлөмжийг тогтмол авдаг гэж өмнөх онд нийт байгууллагын 44% нь хариулж байсан бол энэ жил 61% болж нэмэгдсэн. Гэвч цахим хуудсанд мониторинг хийх үед “Санал хүсэлт болон гомдол гаргах механизм бий эсэх (Утас, и-мэйл)” гэсэн шалгуур үзүүлэлт дээр нийт 97 байгууллагын цахим хуудаснаас ердөө 22 байгууллага нь л шаардлага хангасан байдаг. Үүнтэй адилаар цахим хуудсанд хандсан хандалтын тоог мэдээллийн цахим ил тод байдлыг сайжруулах төлөвлөгөө, үр дүн зэрэгт тусгадаг гэж нийт байгууллагын 72% нь хариулсан. Гэвч цахим хуудсанд хандсан хүний тоог 31 байгууллага дээр л харагддаг.

Цахим хуудасны технологийн хувьд нийгмийн сүлжээ рүү холбогдох холбоос, үйлчилгээний цахим холбооснууд рүү холбогдох холбоос, чатбот, бүх төхөөрөмжөөс хандахад ижил харагдах байдал, сайтын бүтэц, дотоод хайлтын систем, хэлний сонголт зэрэг нь жил бүр тасралтгүй хөгжиж байгаа үзүүлэлтүүд юм.

ЗУРАГ 8

Баримт бичгийг ойлгомжтойгоор хүртээмжтэй байршуулсан жишээ

Бүрдэхүүн	#	Гарчиг	Дугаар	Огноо	Хавсралт
ТАЗ-с гаргасан зөвлөмж, шийдвэр		Хайлтын утга	Хайлтын	Хайлтын ут	Хайлт
Тогтоол шийдвэр					Yarak / Tatak
Сул орон тоо					Yarak / Tatak
Иргэний нөөцийн жагсаалт					Yarak / Tatak
Сонгон шалгаруулалт					Yarak / Tatak
Тайлан мэдээ					Yarak / Tatak
	21	Дэлгэрхан сумын Засаг даргыг Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	59	2022.06.09	Yarak / Tatak
	22	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн асуудлыг байдал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	48	2022.06.09	Yarak / Tatak
	23	Жаргалтхан сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	39	2022.06.09	Yarak / Tatak
	24	Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	66	2022.06.09	Yarak / Tatak
	25	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	57	2022.06.09	Yarak / Tatak
	26	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Гурванбуган тосгоны Хөдөлмөр хэрлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	46	2022.06.09	Yarak / Tatak
	27	Батхэрвэ сумын Сайнхан төвийн даргын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	74	2022.06.09	Yarak / Tatak
	28	Баян-Адагга сумын Засаг даргын Тамгын газрын даргын сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	37	2022.06.09	Yarak / Tatak
	29	Жаргалтхан сумын Засаг даргыг Тамгын газрын Хүнс жижиг дунд үйлдвэр, хэрэгсэл асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	64	2022.06.09	Yarak / Tatak
	30	Аймгийн Татварын хяналтын Татварын үлсөн байцаагчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	53	2022.06.09	Yarak / Tatak
	31	Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хүний нөөцийн, эрх зүйн асуудал хариуцсан албан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	55	2022.06.09	Yarak / Tatak

ЗУРАГ 9

Баримт бичгийг ойлгомжгүй, хүртээмжгүй байршуулсан жишээ

 2023-04-17 08:06 Засаг даргын захирамж /2023 он А/88 - А/113/ Засаг даргын захирамж /2023 он А/88 - А/113/ Далгэрэнгүй	 2023-03-27 09:45 Засаг даргын захирамж /2023 он А/72 - А/87/ Засаг даргын захирамж /2023 он А/72 - А/87/ Далгэрэнгүй
 2023-03-01 11:17 Засаг даргын захирамж /2023 он А/88 - А/113/	 2023-02-13 10:15 Засаг даргын захирамж /2023 он А/72 - А/87/

2.2.4. Цахим мэдээллийн нээлттэй байдал

Энэ бүрэлдэхүүн хэсэгт төрийн байгууллагуудын цахим хуудсаар ил болгож буй нээлттэй мэдээллүүд нь хуульд тогтоосон хугацааны дагуу цахим хуудаст байршиж байгаа эсэхийг тодруулна. Ингэхдээ төрийн байгууллагын цахим хуудсаараа нийтэлж буй мэдээллийн агуулга нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 'нээлттэй мэдээлэл'-ийг хамрах ба хуульд хэр нийцэж байгаад төвлөрнө. Мөн Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад дүрэм журамтай уялдана.

Цахим мэдээллийн нээлттэй байдал 'хангалтгүй' (47.5%) түвшинд үнэлэгдсэн. Энэ үр дүнг 2022 оны үр дүнтэй харьцуулахад 2%-аар өссөн боловч төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Бусад бүрэлдэхүүн хэсэгтэй харьцуулахад жил бүр өөрчлөлт нь төдийлөн сайжрахгүй 'сул' түвшинд хэвээр байна. Хэдийгээр Нийтийн мэдээллийн тухай хууль хэрэгжээд 1 жил гаруйн хугацаа өнгөрсөн боловч цахим нээлттэй байдал хуулийн дагуу сайжраагүй байна. Энэ нь шинэ хуулийн дагуу байгууллагууд мэдээллийг ил тод болгон хэвшүүлэх, шинэчлэл хийхэд хугацаад орж буйтай холбоотой. Үүнийг дэд бүрэлдэхүүн тус бүрээр задлан харвал дараах үр дүн харагдаж байна⁴.

Хүснэгт 5

Цахим мэдээллийн нээлттэй байдлын индекс

#	Дэд бүрэлдэхүүн	2022 оны индекс	2023 оны индекс	Өөрчлөлт
1	Цахим мэдээллийн нээлттэй байдал	45.6%	47.5%	+1.9%
2	Нээлттэй мэдээлэл	38.5%	42.0%	+3.5%
3	Харилцаа холбоо ба эргэх холбоо	5.8%	5.5%	-0.3%

⁴ Цахим мэдээллийн нээлттэй байдлын бүрэлдэхүүний оноо дэд бүрэлдэхүүн тус бүрийн нийлбэрээр тодорхойлогдоно.

Нийтийн мэдээллийн тухай хууль 'нээлттэй' байхаар заасан төрийн байгууллага бүрд хамааралтай ерөнхий мэдээллийг агуулгаар нь харвал байгууллагатай холбоо барих хаяг, утас, байршлын мэдээлэл 1-2 байгууллагаас бусад нь бүгд ил тод байна.

Байгууллагын холбоо барих мэдээлэл хэсэгт цагийн хуваарь, утасны дугаар, цахим шуудан, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг жигд бүрэн орсон. Харин байгууллагын хаягийг текст хэлбэрээр дийлэнх байгууллага бичсэн бөгөөд байршлыг заасан хаягийн мэдээллийг газрын зурагт байршуулах хэлбэрээр оруулж өгөх хэрэгтэй байна. Мөн хэд хэдэн байгууллагын газрын зураг алдаатай, буруу газар заасан бөгөөд тэдгээрийг шалгаж, шинэчлэх шаардлагатай байна.

Өнгөрсөн жилийн хувьд тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг олонх байгууллагууд байршуулаагүй байсан бол энэ жилийн хувьд дийлэнх байгууллага байршуулжээ.

Статистик болон судалгааны мэдээлэл, тайлан багтсан эсэх үзүүлэлт бүх байгууллага дээр жигд ил тод байршсан байна. Үүнд:

- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт
- Статистик мэдээлэл
- Судалгаа, шинжилгээний тайлан
- Үйл ажиллагааны тайлан
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан
- Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, ЗГ-ын шийдвэр, бусад акт

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах мэдээллүүд маш сайн орж байгаа хэдий ч тэдгээрийн шинэчлэлийг харуулсан баримт оруулж өгөх шаардлагатай байна. Шинээр орсон болон ажлаас гарсан албан хаагчдын мэдээллийг сар бүр шинэчилж байх нь иргэдэд шаардлагатай албан хаагчидтай уулзах, утсаар холбогдож мэдээлэл авах үйл явцыг саадгүй болгоход дөхөм болгох юм. Үүнээс гадна сул орон тооны зар, албан хаагчтай холбоотой дүрэм, журмууд, албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлэх болон хүний нөөцийн удирдлагыг ил тод болгох чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга

хэмжээнүүдийн талаарх мэдээллийг ч ихэнх байгууллага байршуулжээ.

Төсвийн ил тод байдлын талаарх мэдээллийг төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлийг бүтэн жилээр байршуулсан байдал сайн байгаа боловч улирал, хагас жилээр байршуулж, цаг тухай бүрд нь оруулах байдал бага зэрэг сул байна. Шилэн дансны цахим хуудсанд тогтмол байршуулах мэдээллүүдийг хугацаа хоцроон байршуулж байгаа дутагдал нийт төрийн байгууллагуудад дахин давтан гарсаар байна. Мөн байршуулаагүй үзүүлэлтийг нөхөн байршуулах үүргийг холбогдох албан тушаалтанд өгч хэрэгжилтийг хангуулах хэрэгцээтэй байна.

Төрийн аудитын дээд газар болох Үндэсний аудитын газраас 2015-2021 оны хооронд шилэн дансны хэрэгжилтэд жил бүр хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгдөг. 2019 онд хийсэн үнэлгээгээр төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ) болон тэдгээрт хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг 91.5% тай, нийслэлийн төсөвт хамаарах байгууллагууд 87.9% хэрэгжүүлж ажилласан байна гэсэн дүгнэлт гарсан. Гэтэл энэ хууль маань 100% хувь хэрэгжиж байж үр дүнгээ өгөх ёстой учир хангалтгүй гэж дүгнэгдсэн.

Төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хуулийн хугацаанд цахимаар ил тод болгож, иргэдэд нээлттэй хүргэх нь төсвийн ерөнхийлөн Захирагч нарын үүрэг юм. Төрийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор; аудитын тайлан, дүгнэлтэд тулгамдаж буй асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор тогтмол мэдээлнэ гэсэн заалтын дагуу мэдээллээ байршуулах ёстой. Нийт байгууллагуудын бараг тал хувь (51.8%) нь 2022 оны санхүүгийн аудитын дүгнэлтийг байршуулаагүй байна. Харин аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллээ ердөө 30.6% нь байршуулжээ. Энэ нь өмнөх оныхоос 12.3%-аар буурсан үзүүлэлт юм. Тиймээс аудиттай

холбоотой тайлан мэдээллүүдийг ил тод байршуулах асуудлыг сайжруулах хэрэгцээ, шаардлагатай байна.


Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хууль заасан үзүүлэлтүүдээр хэмжихэд ихэнх байгууллага худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн урилга, баримт бичиг зэрэг мэдээллүүдээ ил тод нээлттэй байршуулсан байна. Харин 60 гаруй хувь нь тендер шалгаруулалтын үр дүн болон шалтгаан зэргийг байршуулаагүй байгаа нь эдгээр үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай харагдаж байна. Түүнчлэн, 5 сая ба түүнээс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл болон худалдан авах ажиллагааны аудит, бусад шалгалтын тайлан, дүгнэлтийг ихэнх байгууллага байршуулаагүй хэвээр байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн агуулгаар мэдээллээ хамгийн ил тод байршуулсан байгууллага нь (i) Барилга, хот байгуулалтын яам, (ii) Зам тээвэр хөгжлийн яам, (iii) Сангийн яам байна. Барилга хот байгуулалтын яамны хувьд өнгөрсөн жил ч мөн адил нэгдүгээрт эрэмбэлэгдэж байв. Байгууллага тус бүрээр ерөнхийд нь дүгнэвэл яамд мэдээллээ ил тод

байршуулах байдал бусад байгууллагатай харьцуулахад хамгийн сайн байна. Тэр дундаа төсөв, худалдан авах төлөвлөгөөний ил тод байдал бүх яамны хувьд жигд ил тод байна. Хэрэглэгчидтэй харилцах ба эргэх холбоотой ажиллах нь тэдний мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Төрийн байгууллагууд хаяг, холбоо барих утасны мэдээлэл болон холбогдох албан тушаалтны нэр, холбоо барих мэдээллийг нээлттэй ил тод байршуулах байдал маш өндөр байгаа боловч бодит байдал дээр утсаа авдаггүй, хариу өгдөггүй байдал нийтлэг ажиглагдлаа. Мөн утас нь солигдох, эзэмшигч нь өөрчлөгдөх зэрэг нь түгээмэл ажиглагдаж байгаа учир энэ нь мэдээллийг түргэн шуурхай цахим хуудас дээр шинэчлэхгүй байгаатай холбоотой юм. Энэ жилийн хувьд чат ботыг нийгмийн сүлжээний хаягт нэвтрүүлэх байдал өмнөх жилээс 20% аар өссөн нь онцлох үзүүлэлт юм. Иргэдэд шуурхай хариу өгөх үйлчилгээнд технологийг ашиглаж байгаа нь цахим шилжилтэд шилжих, цаашлаад энэ чиглэлийн дотоод чадавх төрийн байгууллагуудад сайжирч байгаа нь сайшаалтай.

ЗУРАГ 10

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын иргэдтэй харилцах цахим хуудас



ЗУРАГ 11

Санхүүгийн зохицуулах хорооны иргэдээс өргөдөл, гомдол авах хэсэг

Өргөдөл

Өргөдлийн агуулга •

Агуулгаа энд бичнэ үү...

Өргөдөл гаргагчийн нэр •

Нэрээ энд бичнэ үү...

Өргөдлийн товч утга •

Товч утгаа энд бичнэ үү...

Оршин суугаа газрын хаяг •

Оршин суугаа газрын хаягаа энд бичнэ үү...

Утасны дугаар •

Утасны дугаараа энд бичнэ үү...

Майлн хаяг •

Майлаа энд бичнэ үү...

Зөмжүүлэлтийн салбар •

Салбар...

ХИГЭЭХ

2.3. Байгууллагуудын үр дүн

Энэ хэсэгт индексийн үр дүнг байгууллагын түвшинд ангилан авч үзнэ. Төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдлын үнэлгээнд дараах 6 төрлийн байгууллагыг жил бүр хамруулж үр дүнг гаргаж ирсэн.

Нийт байгууллагын үр дүнг харахад бүх байгууллагын мэдээллийн цахим ил тод байдал өнгөрсөн онтой харьцуулахад өсжээ.

Эдгээр байгууллагуудаас Яам, Хэрэгжүүлэгч агентлаг, болон Аймгийн ЗДТГ нарын үр дүн өнгөрсөн онтой харьцуулахад хамгийн их өсөлт үзүүлсэн байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 2022 онд “Цахим-аймаг” бодлогын зөвлөмжийг боловсруулсан. Аймаг бүрд мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах, төрийн дижитал шилжилтийг хэрэгжүүлэх, бодлогын удирдамжаар хангах чиг үүрэг бүхий СІО (Chief Information Officer) -ийн орон тоог бий болгохоор төлөвлөж ажилласан. Яамдын хувьд Зам тээвэр хөгжлийн яам нийт байгууллагуудаас тэргүүлж (81%), хоёрт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (77%), гуравт Байгаль орчин аялал жуулчлалын яам (76%) эрэмбэлэгдлээ. Нийт аймгийн ЗДТГ-ын цахим ил тод байдал 2022

онд хамгийн их өсөлт үзүүлжээ. Өнгөрсөн онд хэд хэдэн аймгийн ЗДТГ-ын цахим хуудаснууд шинэчлэгдэж байсан бөгөөд 2023 оны хувьд мэдээлүүд нэлээн тогтмолжиж, шаардлагатай шинэчлэлүүдийг цаг тухай бүрд нь оруулсан байгаа нь нөлөөлсөн гэж дүгнэж болно.

2022 оны мониторингоор ‘хангалтгүй’ ангилалд хоёр байгууллага багтаж байсан бол 2023 онд эдгээр байгууллагууд ‘сул’ түвшинд ахиснаар төрийн байгууллагын цахим ил тод байдлын түвшин нийтээрээ дээшилж байгааг харж болох юм. Тодруулбал, Мал эмнэлгийн ерөнхий газрын цахим ил тод байдал 20.8%-аар өсөж, ‘хангалтгүй’ түвшнээс ‘сул’ түвшинд, Төрийн тусгай хамгаалалтын газрын цахим ил тод байдал 12.2%-аар өсөж мөн ‘хангалтгүй’ түвшнээс ‘сул’ түвшинд үнэлэгдлээ.

Бүрэлдэхүүн тус бүрээр нь харвал Яамдын бодлогын орчин хамгийн сайн, Байгууллагын чадамжийн хувьд Аймаг, Хэрэгжүүлэгч агентлаг хамгийн сайн, мэдээллийн цахим нээлттэй байдал Яамдын дунд хамгийн сайн байна.

Ерөнхийд нь дүгнэвэл Тохируулагч агентлаг болон Дүүргийн ЗДТГ-ын дундаж индекс ‘сул’ түвшинд, бусад дөрвөн ангиллын байгууллагын дундаж индекс ‘хангалттай’ түвшинд байна. Байгууллагын төрөл тус бүрээр ангилсан эрэмбийг Хавсралт 2-оос харна уу.

ХҮСНЭГТ 6

Үр дүн, байгууллагын ангиллаар

#	Байгууллагын төрөл	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал	2023 оны индекс	2022 оны индекс	Өөрчлөлт
1	Монгол Улсын Яамд	78.9%	74.8%	58.3%	70.7%	66.6%	+4.1%
2	Хэрэгжүүлэгч агентлагууд	79.7%	75.4%	45.0%	66.8%	62.5%	+4.3%
3	Тохируулагч агентлагууд	79.0%	62.8%	47.4%	63.1%	61.2%	+2.9%
4	Аймгуудын ЗДТГ	78.9%	75.4%	43.5%	66.1%	61.4%	+4.7%
5	Дүүргүүдийн ЗДТГ	78.2%	70.2%	44.5%	63.8%	62.7%	+1.1%
6	Парламентын харьяа байгууллагууд	79.8%	68.5%	48.8%	65.7%	64.5%	+1.2%
Ерөнхий дундаж		78.8%	66.2%	44.2%	65.2%	63.1%	+2.1%

3. Дүгнэлт, зөвлөмж

Төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдал индекс 65.2% болсон нь төрийн байгууллагуудын мэдээллийн цахим ил тод байдлын индексийг үнэлж эхэлснээс хойш 12 жилийн дараа анх удаа ‘хангалттай’ түвшинд хүрлээ. Уг үр дүнг 2022 онтой харьцуулахад (63.1%) бага зэрэг буюу 2.1%-аар өссөн байгаа ч ангиллын хувьд нэг түвшин ахисан амжилттай байна. Нийт хамрагдсан төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлын түвшнийг ангилан харвал 55% нь ‘сайн’ болон ‘хангалттай’ түвшинд үлдсэн нь ‘сул’ түвшинд үнэлэгдсэн.

Өмнөх онуудад ‘сайн’ буюу 80%-аас дээш түвшинд цахим мэдээллийн ил тод байдлаа хангасан байгууллага байгаагүй бол энэ жилийн хувьд хоёр байгууллага сайн түвшинд үнэлэгдсэн нь төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдал жил ирэх тусам сайжирч иргэдэд нээлттэй мэдээлэл хүргэх байдал дээшилж буй эерэг үр дүн юм.

Бодлогын орчны дэд индекс ‘хангалттай’ (79.2%) түвшинд үнэлэгдсэн. Энэ үр дүнг 2022 оны үр дүнтэй харьцуулахад (78.8%) бага зэрэг буюу 0.4%-аар өссөн үзүүлэлт юм. Бодлогын орчинд хамаарах дэд 5 бүлэг ерөнхий бүгд эерэг ахицтай үнэлэгдсэн. Сүүлийн жилүүдэд бодлогын орчин харьцангуй сайн бүрэлдэн тогтож, хууль, журмуудын хэрэгжилт тогтворжиж шинэ хуулийг дагалдан гарч буй журмууд шинээр болон шинэчлэгдэн батлагдсаар байна. Ялангуяа МУЗГ-т Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдаж тусдаа бүтэц бий болсноор төрийн байгууллагуудын цахимжилт эрчимжиж, мэдээллийг ил тод, нийтэд түргэн шуурхай түгээх байдал нэмэгдэж байна. Гэвч ихэнх байгууллагууд урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичигтээ мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр заалт оруулж өгсөн боловч дийлэнхдээ уламжлалт байдлаар хурал, уулзалт маягаар мэдээлэл түгээх аргыг ашиглах байдлаар тусгагдсан байна. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд гаргасан

журам, тушаал гаргах байдал сул байгаа нь уг хуулийн хэрэгжилтийг байгууллага дотооддоо төлөвшүүлж чадахгүй байна. Түүнчлэн журам, тушаалын агуулгад мэдээллийн хүрээг нарийвчлан тодорхойлох, үйл явц болон хариуцагчийг тодорхой болгох, хяналтын механизм, үр дүнг үнэлэх, нөөц зэргийг тусгах хэрэгцээ шаардлагатай байна.

Байгууллагын чадамжийн дэд индекс ‘хангалттай’ (72.8%) түвшинд үнэлэгдсэн. Энэ нь өмнөх оны үр дүнтэй (2022 онд 66.2%) харьцуулахад мэдэгдэхүйц буюу 6.6%-аар өссөн үзүүлэлт юм. Энэ нь төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдлын ерөнхий индекс сул түвшнээс хангалттай түвшинд үнэлэгдэхэд чухал нөлөө үзүүлсэн. Энэ нь төрийн байгууллагууд мэдээллийн цахим ил тод байдлыг бий болгох дотоод төлөвлөгөө, стратегийг байгууллагуудын тал хувь нь бий болгосноор ахиц гарахад чухал нөлөө үзүүлсэн байна. Гэвч тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг талаас бага хувь нь төлөвлөгөөний дагуу бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлж байгаагаас үүдэж “сайн” ангилал руу дээшилж чадахгүй байна. Байгууллага бүр дээр жил бүр хамгийн бага буюу муу үнэлгээ авдаг үзүүлэлт бол мэдээллийн цахим ил тод байдлынхаа гүйцэтгэлийг тогтмол хянаж үнэлэх юм. Тиймээс байгууллагууд дотооддоо цахим мэдээллийн ил тод байдлаа үнэлэх, хянах механизмыг нэвтрүүлж тогтмол хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай байна.

Мэдээллийн цахим нээлттэй байдлын дэд индекс “хангалтгүй” (47.5%) түвшинд үнэлэгдсэн. Энэ үр дүнг 2022 оны үр дүнтэй харьцуулахад 2%-аар өссөн хэдий ч төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Бусад бүрэлдэхүүн хэсэгтэй харьцуулахад жил бүр эерэг өөрчлөлт нь бага мэдрэгдэж сул түвшинд байсаар байгаа. Хэдийгээр Нийтийн мэдээллийн тухай хууль хэрэгжээд 1 жил гаруйн хугацаа өнгөрч байгаа ч цахим нээлттэй байдал хуулийн дагуу сайжрахгүй байна. Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд гаргасан журам, тушаал гаргах байдал

сул, уг хуулийн хэрэгжилтийг байгууллага дотооддоо төлөвшүүлж чадахгүй байгаатай холбоотой юм. Тиймээс шинэ хуулийн хүрээнд байгууллага дотооддоо нийтийн мэдээллийг ил тод байдлыг хангах журам, тушаалыг батлан гаргах, хэрэгжүүлэлтийг тогтворжуулах хэрэгцээ шаардлагатай байна.

Мэдээллийн цахим ил тод байдлын нэг чухал үзүүлэлт болох технологийн хувьд байгууллагуудын цахим хуудаснаас хэрэглэгчид хэрэгтэй мэдээллээ хялбар хайж олох, шууд харилцах, үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид төрийн байгууллагууд мэдээллийн цахим ил тод байдлаа сайжруулах дараах санал зөвлөмжүүдийг хүргэж байна. Үүнд:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /шинэчлэгдсэн найруулга/ хуулийн хүрээнд байгууллага дотооддоо нийтийн мэдээллийг ил тод байдлыг хангах журам, тушаалыг батлан гаргах, хэрэгжилтийг тогтворжуулах, агуулгад мэдээллийн хүрээг нарийвчлан

тодорхойлох, үйл явц болон хариуцагчийг тодорхой болгох, хяналтын механизм, үр дүнг үнэлэх, нөөц зэргийг тусгах

- Мэдээллийн цахим ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэд, олон нийт болон судалгаа шинжилгээний байгууллагаас ирсэн санал, гомдолд байгууллага бүр жил тутам шинжилгээ хийж, цаашид хэрхэн сайжруулж болох талаар төлөвлөгөө боловсруулж, ирэх жилийн үйл ажиллагаандаа шаардлагатай нөөцийн хамт тусгах
- Байгууллагууд цахим хуудаснаас хэрэглэгчид хэрэгтэй мэдээллээ хялбар хайж олох, шууд харилцах, санал гомдол хүлээн авах болон үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх
- Байгууллагын цахим хуудсанд байршуулж буй нээлттэй өгөгдөл, баримт бичиг зэргийн өргөтгөлийг төрөлжүүлэх, байршуулсан нээлттэй өгөгдөл, баримт бичиг зэргийг тогтмол шалгаж татан авах, ашиглах боломжийг тасралтгүй нэмэгдүүлэх. Мөн байршуулсан мэдээлэл, нээлттэй өгөгдөл, баримт бичгийн нийтлэгдсэн огноо, шинэчлэгдсэн огноог тогтмол оруулах

Хавсралт 1. Арга зүй: Хэмжих индикаторууд, харгалзах оноо

Код	Индикаторууд	Дээд оноо
Е. Бодлогын орчин		57
Е1. Мэдээлэл авах эрх (Олон улс)		8
E1.1	Мэдээлэл хүсэх эрх	2
E1.2	Мэдээллийн цар хүрээ	1
E1.3	Мэдээлэл хүсэх журам	1
E1.4	Татгалзал	1
E1.5	Гомдол гаргах	1
E1.6	Санкц ба хамгаалалт	1
E1.7	Таниулах арга хэмжээ	1
Е2. Засаглал (Олон улс)		12
E2.1	Хуулийн хэрэгжилт	2
E2.2	Дуу хоолой ба хариуцлага	1
E2.3	Зохицуулалтын чанар	1
E2.4	Засгийн газрын үр нөлөөтэй байдал	1
E2.5	Төрийн төлөв байдал	4
E2.6	Төрийн үйл ажиллагаа	3
Е3. Иргэний нийгэм (Олон улс)		15
E3.1	Иргэний оролцоо	2
E3.2	Хэвлэлийн эрх өлөө	1
E3.3	Иргэний нийгмийн төлөв байдал	1
E3.4	Цахим оролцоо	1
E3.5	Иргэний эрх чөлөөний хяналт (эрх зүйн)	1
E3.6	Засаглалд иргэдийг оролцуулах	4
E3.7	Эрх чөлөө	5
Е4. Улсын түвшний бодлого, зохицуулалт		14
E4.1	Хууль, журам	5
E4.2	Бодлого төлөвлөлт	5
E4.3	Хэрэгжүүлэх субъект	3
E4.4	Хяналт тавих механизм	1
Е5. Байгууллагын түвшний зохицуулалт		8
E5.1	Зохицуулалт	8
О. Байгууллагын чадамж		29
О1. Байгууллагын ил тод байдлыг хангах үйл явц ба нөөц		12
O1.1	Нөөцийн боломжит байдал	3
O1.2	Манлайлал	5
O1.3	Тасралтгүй сайжруулах чадавх	4
О2. Цахим хуудасны технологийн нийцтэй байдал		11
O2.1	Цахим хуудасны нийцтэй байдал	11
О3. МХТ-ийн чадавх		6
O3.1	МХТ-ийн чадавх	6
Д. Цахим нээлттэй мэдээлэл		48
Д1. Нээлттэй мэдээлэл		39
O1.1	Нөөцийн боломжит байдал	3
D1.1	Үйл ажиллагааны ил тод байдал	13
D1.2	Хүний нөөцийн ил тод байдал	9
D1.3	Төсөв, санхүүгийн ил тод байдал	10
D1.4	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	7
Д2. Харилцаа холбоо ба эгэх холбоо		9
D2.1	Харилцаа ба эгэх холбоо	9
Нийт		150

Хавсралт 2. Байгууллагын төрөл тус бүрийн эрэмбэ

Сайн | >80

Хангалттай | 65-79

Сул | 50-64

Хангалтгүй | 35-49

Муу | <35

Яамдын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Зам, тээврийн хөгжлийн яам	81%	78%	92%	73%
2	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам	77%	78%	93%	60%
3	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	76.3%	78%	91%	60%
4	Сангийн яам	75.7%	78%	84%	65%
5	Барилга, хот байгуулалтын яам	73.1%	79.2%	65%	75%
6	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	73.1%	79.2%	91%	49%
7	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	73%	78%	76%	65%
8	Гадаад харилцааны яам	72.7%	86%	77%	55%
9	Эрүүл мэндийн яам	69.3%	83%	77%	48%
10	Боловсрол, шинжлэх ухааны яам	68.7%	78%	64%	64%
11	Соёлын яам	67%	78%	65%	58%
12	Эдийн засаг, хөгжлийн яам	66.3%	78%	70%	51%
13	Батлан хамгаалах яам	65.7%	78%	62%	57%
14	Эрчим хүчний яам	65.3%	78%	69%	49%
15	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	63.7%	78%	56%	57%
16	Хууль, зүй дотоод хэргийн яам	63.7%	78%	65%	48%
Яамдын индекс		70.7%	78.9%	74.8%	58.3%
Улсын цахим ил тод байдлын индекс		66.5%	79.2%	72.8%	47.5%

Тохируулагч агентлагуудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Цагдаагийн ерөнхий газар	66.5%	78.0%	72.2%	49.2%
2	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	65.6%	78.0%	64.8%	53.9%
3	Стандарт, хэмжил зүйн газар	64.3%	78.0%	70.2%	44.5%
4	Онцгой байдлын ерөнхий газар	64.1%	78.0%	60.5%	53.9%
5	Зэвсэгт хүчний жанжин штаб	63.5%	78.0%	72.0%	40.6%
6	Төрийн тусгай хамгаалалтын газар	63.1%	78.0%	66.0%	45.3%
7	Тагнуулын ерөнхий газар	61.5%	78.0%	67.3%	39.1%
8	Хил хамгаалах ерөнхий газар	59.5%	78.0%	53.0%	47.6%
9	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	54.7%	78.0%	43.9%	42.2%
Тохируулагч агентлагийн индекс		61.2%	78.0%	60.2%	45.4%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Сайн | >80

Хангалттай | 65-79

Сул | 50-64

Хангалтгүй | 35-49

Муу | <35

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	80.5%	84.5%	96%	61%
2	Татварын ерөнхий газар	74.3%	78%	86%	59%
3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	73.2%	78.5%	83%	58%
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	72.7%	84%	77%	57%
5	Усны газар	72.3%	78%	94%	45%
6	Биеийн тамир, спортын улсын хороо	70.8%	83.5%	89%	40%
7	Цаг уур, орчны шинжилгээний газар	70%	78%	91%	41%
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	70%	78%	84%	48%
9	Биеийн тамир, спортын газар	70%	78%	90%	42%
10	Ойн газар	69.7%	84%	82%	43%
11	Шүүх шинжилгээний ерөнхий газар	68.7%	78%	80%	48%
12	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	68.3%	78%	91%	36%
13	Боловсролын ерөнхий газар	67.7%	79%	85%	39%
14	Үндэсний геологийн алба	67.2%	82.5%	78%	41%
15	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	66.7%	80%	74%	46%
16	Ашигт малтмал, газрын тосны газар	65.8%	83.5%	74%	40%
17	Төрийн худалдан авах ажиллагааны газар	65.2%	82.5%	71%	42%
18	Нийгмийн даатгалын ерөнхий газар	64.3%	78%	73%	42%
19	Мал эмнэлгийн ерөнхий газар	64.3%	78%	73%	42%
20	Жижиг, дунд үйлдвэрийн газар	64%	78%	70%	44%
21	Иргэний нисэхийн ерөнхий газар	63.2%	83.5%	64%	42%
22	Улсын бүртгэлийн ерөнхий газар	63%	78%	66%	45%
23	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	62.7%	78%	69%	41%
24	Оюуны өмчийн газар	62.3%	78%	65%	44%
25	Архивын ерөнхий газар	62.3%	84%	59%	44%
26	Гадаадын иргэн, харьяатын газар	62.3%	78%	65%	44%
27	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	62%	78%	61%	47%
28	Соёл, урлагийн газар	61.3%	78%	63%	43%
29	Гаалийн ерөнхий газар	59%	78%	61%	38%
30	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	58.7%	78%	50%	48%
Хэрэгжүүлэгч агентлагийн индекс		66.8%	79.7%	75.4%	45%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Аймгийн ЗДТГ-уудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Өвөрхангай аймаг	77.5%	78.5%	94%	60%
2	Орхон аймаг	74.3%	78%	93%	52%
3	Завхан аймаг	71%	78%	94%	41%
4	Увс аймаг	70.7%	78%	93%	41%
5	Архангай аймаг	69.7%	80%	83%	46%
6	Дундговь аймаг	69.7%	78%	89%	42%
7	Сэлэнгэ аймаг	69.7%	78%	89%	42%
8	Хэнтий аймаг	68.7%	80%	85%	41%
9	Булган аймаг	67.3%	78%	70%	54%
10	Баянхонгор аймаг	67%	80%	77%	44%
11	Дархан-Уул аймаг	66.2%	79.5%	77%	42%
12	Баян-Өлгий аймаг	65.2%	82.5%	74%	39%
13	Ховд аймаг	64.2%	78.5%	73%	41%
14	Өмнөговь аймаг	63.2%	78.5%	57%	54%
15	Говь-Алтай аймаг	63%	78%	67%	44%
16	Дорнод аймаг	63%	80%	72%	37%
17	Говьсүмбэр аймаг	61.7%	80%	63%	42%
18	Дорноговь аймаг	61.7%	80%	64%	41%
19	Хөвсгөл аймаг	58.8%	78.5%	60%	38%
20	Төв аймаг	57.5%	78.5%	59%	35%
21	Сүхбаатар аймаг	55.7%	78%	51%	38%
22	Улаанбаатар хотын захирагчийн алба	66.2%	78%	85%	45%
Аймаг, нийслэлийн дундаж		66.1%	78.9%	75.8%	43.5%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Дүүргийн ЗДТГ-уудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Налайх дүүрэг	67.1%	78%	87%	55%
2	Баянзүрх дүүрэг	66.8%	78%	86%	50%
3	Хан-Уул дүүрэг	65.4%	78%	85%	45%
4	Багахангай дүүрэг	64.4%	78%	64%	44%
5	Багануур дүүрэг	63.7%	78%	62%	42%
6	Чингэлтэй дүүрэг	60.3%	78.5	64%	38%
7	Сонгинохайрхан дүүрэг	59.6%	78.5%	57%	44%
8	Баянгол дүүрэг	51.2%	78%	57%	42%
9	Сүхбаатар дүүрэг	58.2%	79.5%	55%	40%
Дүүргүүдийн дундаж		63.8%	78.2%	68.5%	44.4%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Сайн | >80

Хангалттай | 65-79

Сул | 50-64

Хангалтгүй | 35-49

Муу | <35

Парламентын харьяа байгууллагуудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Монгол банк	74.5%	81.5%	77%	65%
2	Санхүүгийн зохицуулах хороо	70.5%	79.5%	69%	63%
3	Үндэсний статистикийн хороо	68.5%	85.5%	69%	51%
4	Сонгуулийн ерөнхий хороо	65.3%	78%	67%	51%
5	Жендэрийн үндэсний хороо	64.2%	79.5%	69%	44%
6	Авлигатай тэмцэх газар	64%	80%	64%	48%
7	Хүний эрхийн үндэсний комисс	63.7%	78%	72%	41%
8	Үндэсний аудитын газар	63.3%	78%	72%	40%
9	Монгол улсын их хурал	63%	80%	65%	44%
10	Төрийн албаны зөвлөл	60%	78%	61%	41%
Парламентын харьяа байгууллагын индекс		65.7%	78.0%	68.1%	48.8%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Хавсралт 3. Нийт үнэлсэн төрийн байгууллагуудын эрэмбэ

Сайн | >80 Хангалттай | 65-79 Сул | 50-64 Хангалтгүй | 35-49 Муу | <35

Эрэмбэ	Байгууллагууд	2022 оны индекс	2023 оны индекс	Өөрчлөлт
1	Зам, тээврийн хөгжлийн яам	64.1%	81.0%	16.9%
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	72.6%	80.5%	7.9%
3	Өвөрхангай аймаг	74.6%	77.5%	2.9%
4	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам	74.7%	77.0%	2.3%
5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	65.9%	76.3%	10.4%
6	Сангийн яам	75.3%	75.7%	0.4%
7	Монгол банк	70.7%	74.5%	3.8%
8	Татварын ерөнхий газар	70.1%	74.3%	4.2%
8	Орхон аймаг	61.5%	74.3%	12.8%
9	Налайх дүүрэг	60.3%	73.3%	13.0%
10	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	70.1%	73.2%	3.1%
11	Барилга, хот байгуулалтын яам	76.8%	73.1%	-3.7%
11	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	66.1%	73.1%	7.0%
12	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	71%	73.0%	2.0%
13	Гадаад харилцааны яам	69.5%	72.7%	3.2%
13	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	67%	72.7%	5.7%
14	Усны газар	65.8%	72.3%	6.5%
15	Цагдаагийн ерөнхий газар	65.6%	72.2%	6.6%
16	Баянзүрх дүүрэг	63.7%	71.3%	7.6%
17	Завхан аймаг	58%	71.0%	13.0%
18	Биеийн тамир, спортын улсын хороо	56.7%	70.8%	14.1%
19	Увс аймаг	64.4%	70.7%	6.3%
20	Санхүүгийн зохицуулах хороо	66.7%	70.5%	3.8%
21	Цаг уур, орчны шинжилгээний газар	61.1%	70.0%	8.9%
21	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	57.9%	70.0%	12.1%
21	*Биеийн тамир, спортын газар		70.0%	70.0%
22	*Ойн газар		69.7%	69.7%
22	Архангай аймаг	57.2%	69.7%	12.5%
22	Дундговь аймаг	58.2%	69.7%	11.5%
22	Сэлэнгэ аймаг	57%	69.7%	12.7%
23	Эрүүл мэндийн яам	62%	69.3%	7.3%
23	Улаанбаатар хотын захирагчийн алба	63.4%	69.3%	5.9%
23	Хан-Уул дүүрэг	66.8%	69.3%	2.5%
24	Боловсрол шинжлэх ухааны яам	59.3%	68.7%	9.4%
24	*Шүүх шинжилгээний ерөнхий газар		68.7%	68.7%
24	Хэнтий аймаг	59.6%	68.7%	9.1%
25	Үндэсний статистикийн хороо	63.1%	68.5%	5.4%
26	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	65.9%	68.3%	2.4%
26	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	64.3%	68.3%	4.0%
27	Боловсролын ерөнхий газар	59.5%	67.7%	8.2%
28	Булган аймаг	63%	67.3%	4.3%
29	Үндэсний геологийн алба	61.9%	67.2%	5.3%
30	Соёлын яам	63.1%	67.0%	3.9%
30	Баянхонгор аймаг	63.9%	67.0%	3.1%

Эрэмбэ	Байгууллагууд	2022 оны индекс	2023 оны индекс	Өөрчлөлт
31	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	63.3%	66.7%	3.4%
32	Эдийн засаг, хөгжлийн яам	58.3%	66.3%	8.0%
33	Дархан-Уул аймаг	64.3%	66.2%	1.90%
34	Ашигт малтмал, газрын тосны газар	59.1%	65.8%	6.70%
35	Батлан хамгаалах яам	65.2%	65.7%	0.50%
36	Эрчим хүчний яам	65.7%	65.3%	-0.40%
36	Сонгуулийн ерөнхий хороо	63.7%	65.3%	1.60%
37	Төрийн худалдан авах ажиллагааны газар	69.5%	65.2%	-4.30%
37	Баян-Өлгий аймаг	61.4%	65.2%	3.80%
38	Нийгмийн даатгалын ерөнхий газар	56.1%	64.3%	8.20%
38	Мал эмнэлгийн ерөнхий газар	43.5%	64.3%	20.80%
38	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	66.5%	64.3%	-2.20%
39	Ховд аймаг	57.6%	64.2%	6.60%
39	Жендерийн үндэсний хороо	66.6%	64.2%	-2.40%
40	Жижиг, дунд үйлдвэрийн газар	63%	64.0%	1.00%
40	Стандарт, хэмжил зүйн газар	63.1%	64.0%	0.90%
40	Авлигатай тэмцэх газар	66.4%	64.0%	-2.40%
41	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	69%	63.7%	-5.30%
41	Хууль, зүй дотоод хэргийн яам	60.2%	63.7%	3.50%
41	Хүний эрхийн үндэсний комисс	59.7%	63.7%	4.00%
42	Онцгой байдлын ерөнхий газар	64.1%	63.5%	-0.60%
43	Үндэсний аудитын газар	66.4%	63.3%	-3.10%
44	Иргэний нисэхийн ерөнхий газар	59.4%	63.2%	3.80%
44	Өмнөговь аймаг	64.9%	63.2%	-1.70%
45	Улсын бүртгэлийн ерөнхий газар	62.8%	63.0%	0.20%
45	Говь-Алтай аймаг	54.9%	63.0%	8.10%
45	Дорнод аймаг	55.8%	63.0%	7.20%
45	Монгол Улсын их хурал	65.2%	63.0%	-2.20%
46	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	61.7%	62.7%	1.00%
46	Зэвсэгт хүчний жанжин штаб	61.5%	62.7%	1.20%
47	Оюуны өмчийн газар	65.7%	62.3%	-3.40%
47	Архивын ерөнхий газар	67.1%	62.3%	-4.80%
48	Гадаадын иргэн, харьяатын газар	63.1%	62.3%	-0.80%
48	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	67.1%	62.0%	-5.10%
49	Багахангай дүүрэг	51.2%	62.0%	10.80%
49	Говьсүмбэр аймаг	65.5%	61.7%	-3.80%
49	Дорноговь аймаг	59.5%	61.7%	2.20%
50	Соёл, урлагийн газар	58.2%	61.3%	3.10%
50	Төрийн тусгай хамгаалалтын газар	49.1%	61.3%	12.20%
51	Багануур дүүрэг	67.1%	60.7%	-6.40%
52	Чингэлтэй дүүрэг	66.2%	60.2%	-6.00%
53	Төрийн албаны зөвлөл	56.8%	60.0%	3.20%
54	Сонгинохайрхан дүүрэг	65.4%	59.8%	-5.60%
55	Тагнуулын ерөнхий газар	59.5%	59.7%	0.20%
55	Гаалийн ерөнхий газар	57.1%	59.0%	1.90%
56	Баянгол дүүрэг	62.2%	59.0%	-3.20%
57	Хөвсгөл аймаг	64.2%	58.8%	-5.40%
58	*Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар		58.7%	58.70%
58	Хил хамгаалах ерөнхий газар	54.7%	58.7%	4.00%

* Шинээр байгуулагдсан болон өмнөх жилд хамрагдаагүй байгууллагууд

Эрэмбэ	Байгууллагууд	2022 оны индекс	2023 оны индекс	Өөрчлөлт
59	Сүхбаатар дүүрэг	59.6%	58.2%	-1.40%
60	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	63.5%	57.7%	-5.80%
61	Төв аймаг	64.3%	57.5%	-6.80%
62	Сүхбаатар аймаг	59.5%	55.7%	-3.80%

* Шинээр байгуулагдсан болон өмнөх жилд хамрагдаагүй байгууллагууд